# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

## НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.1.**<br>**Улсын хэмжээнд хот суурингийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг Дэлхийн геодезийн сүлжээний 2020 эринд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.** | | | | | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.2.**<br>**Навигацын хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станцыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил зураглалын үйл ажиллагаанд ашиглана.** | | | | | | | |
| **1.2.1** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын үйл ажиллагаа** | **Үйл ажиллагаа** | **1.Байнгын ажиллагаатай станц-43**<br>**2.Бодит агшны хяналтын хэмжилт - 4** | **2013-2017 онд Улсын төсвөөр 38, УБ хотын төсвөөр 5 станц суурилуулсан.**<br>**2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн.** | **43 Байнгын ажиллагаатай станцыг нэгдсэн сүлжээнд холбогдож, солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд алдаагүй зөв хэмжилт хийх боломж бүрдсэн байна.** | | |
| 1.2.1.1 | GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Байнгын ажиллагаатай станцын тоо | 2013-2017 онд Улсын төсвөөр 38, нийслэлийн төсвөөр УБ хотод 5 станц суурилуулсан.<br>2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын нэгдсэн удирдлагын | GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын тасралтгүй хэвийн ажиллагааг хангаж ажилласан байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцад гарсан доголдолгүй хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.<br>Мөн GNSS суурин станцын нөлөөллийн судалгааг гарган Газрын даргын 2024 оны 01/116 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тогтолцоо бүрдүүлсэн. | | | |
| 1.2.1.2 | Аймгийн төвийн GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцыг бодит агшны хэмжилтээр хяналт тавих | Үйл ажиллагаа | Бодит агшны хяналтын хэмжилт - 4 | 2020 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын удирдлагын програм хангамжийг шинэчилж, хэрэглээнд нэвтрүүлсэн. | Аймгийн төвд суурилуулсан станцын бодит агшны нарийвчлалыг улиралд 1 удаагийн шалгалтын хэмжилт, сум суурин газрын станцуудад хагас жилд 1 удаагийн шалгалтын хэмжилт хийж, үр дүнг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд бодит агшны хэмжилтийг 4 удаа хийж үр дүнг 192.168.20.24 шэйр дээр байршуулахаас гадна Газрын даргын 2024 оны 01/174, 01/316, 01/388 тоот албан бичгүүдээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.4.<br>Монгол улсын өндрийн тулгуур сүлжээг шинэчилж өндрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулна.** | | | | | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.7.<br>Зайнаас тандан судлалын технологид суурилсан газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ.** | | | | | | | |
| **1.7.1** | **Газар ашиглалт болон газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх** | **Улсын төсөв** | **Мониторингийн 350 цэг** | **2021 онд мониторингийн сүлжээгээр байгуулсан 500 цэгт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил хийгдсэн.** | **Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний 1100 цэгээс мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, бусад байгууллагууд ашиглах нөхцөл боломжоор хангагдсан байна.** | | |
| 1.7.1.2 | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх шаардлагатай газрын байршил, хугацаа, хуваарийн талаарх судалгааг | Үйл ажиллагаа | 1 судалгаа | - | **Эхний хагас жилд:** Сум болон холбогдох байгууллагаас газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийгдсэн газрын байршил, хугацааны талаарх судалгааг авч | Аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар 7866 нэгж талбарт захилагат хянан баталгаар хийлгэх шаардлагатай судалгаа гаргасан. 2024 онд 198 нэгж талбарт захиалгат хянан баталгааг хийлгэх хуваарь гарган хүргүүлсний дагуу 167 нэгж талбарт хийлгүүлэн ажилласан. Дээрх судалгаа, хуваарийг | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аймгийн хэмжээнд гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | | | | нэгтгэнэ. Тус судалгаанд дүн шинжилгээ хийж газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх шаардлагатай газрын байршил, хугацаа, хуваарийн талаарх судалгааг аймгийн хэмжээнд гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлнэ. | 2024 оны 01/173 дугаар тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | |
| **1.7.2** | **Газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих** | **Орон нутгийн төсөв** | **Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний тоо** | **Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалан болон атаршсан газарт нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө батлагдсан. Газрын мониторингийн системийг хэрэглээнд нэвтрүүлснээр газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хянах боломж бүрдсэн.** | **Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалан болон атаршсан газарт нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломж бүрдсэн байна.** | | |
| 1.7.2.1 | Аймгийн хэмжээнд хохирол учирсан, доройтолд өртсөн газруудын байршлыг гаргаж, нөхөн сэргээх байршил, талбайн хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | - | **Эхний хагас жилд:** Газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр хохирол учирсан, доройтолд өртсөн талбайн байршлыг тодорхойлж, нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн хэмжээнд боловсруулж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Аймгийн хэмжээнд хохирол учирсан, доройтолд өртсөн газруудын байршлыг гаргаж, нөхөн сэргээх байршил, талбайн хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж тухайн газруудад техник болон биологийн нөхөн сэргээлт хийхээр Сүмбэр сумын 2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган ажилласан тухайн газарт мод үржүүлгийн зориулалтаар 3га газрыг аймгийн Сум дундын ойн ангид эзэмшүүлээд байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **Жилийн эцэст:** Нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. | | |
| 1.7.2.2 | Аймгийн хэмжээнд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажил болон төлөвлөгөөт хянан баталгааны ажлуудын тайлан, тоон мэдээллийг нэгтгэж, Газрын мониторингийн цахим системд оруулах | Үйл ажиллагаа | Цахим системд оруулсан тоон мэдээлэл | - | **Эхний хагас жилд:** Газрын мониторингийн цахим системд ороогүй 2010-2023 оны хооронд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан, тоон мэдээллийг стандартын дагуу нэгтэж мэдээллийн санг бий болгосон байна. **Жилийн эцэст:** Мэдээллийн санг Газрын мониторингийн цахим системд оруулсан байна. | Газрын мониторингийн цахим системд ороогүй 2010-2023 оны хооронд хийгдсэн 333 нэгж талбарын захиалгат хянан баталгааны тайлан, тоон мэдээллийг нэгтгэж мэдээллийн сан үүсгэн дундын 192.168.20.24 share-д 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдөр байршуулан ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. 2024 онд 167 нэгж талбарын тайланг баталгаажуулан ажиллаад байна. Үүний үр дүнд уг системээр дамжуулан 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 500 нэгж талбарын захиалгат хянан баталгааг цахимаар баталгаажуулан байгууллагын даргын 2024 оны 01/173, 01/369 тоот албан бичгүүдээр хүргүүлсэн. | 100 |
| 1.7.2.3 | Газар хамгаалах, нөхөн сэргээх зардлын зах зээлийн үнийн судалгаа хийх | Үйл ажиллагаа | Судалгаа-1 | - | **Эхний хагас жилд:** Газрын нөхөн сэргээлтийн ажлын үе шатыг нарийвчлан тодорхойлж, нөхөн сэргээлт хийгдэхэд шаардагдсан зардлын мэдээллийг цуглуулж, задаргааг тооцсон судалгааг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Аймгийн хэмжээнд хохирол учирсан, доройтолд өртсөн 31902.84 га газар байгаагаас Сүмбэр суманд 20754.84 га, Баянтал суманд 8125.93 га, Шивээговь суманд 3022.07 га байна. Холбогдох судалгаа аймгийн Байгаль орчны газар, Хөдөө аж ахуйн газар, сумдын ЗДТГ зэрэг байгууллагуудаас авч ойролцоогоор зардлын задаргааг гаргасан. 2024 онд 35,48 га талбайг цэвэрлэж нөхөн сэргээхэд 297,1 сая | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийг зарцуулсан байна. дээрх судалгаа тооцооллыг 2024 оны 01/225 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэн ажилласан. | |
| **1.7.3** | **Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг нэвтрүүлэх** | **Урсгал төсөв** | **Суурь зургууд гарсан байна.** | **2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс Газрын мониторингийн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн.** | **Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглах нэмэлт хөгжүүлэлт хийсэн байна.** | | |
| 1.7.3.1 | Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан, газрын бүрхэвчийн өөрчлөлт, доройтол, элэгдэл, эвдрэл, бэлчээрийн газрын даац, чадавхыг тодорхойлох | Үйл ажиллагаа | Ирүүлсэн тайлангийн тоо | БХБС-ын 2022 оны 126 дугаар тушаалаар “Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх аргачилсан заавар” батлагдсан. | **Жилийн эцэст:** Газрын даамал, мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж, хиймэл дагуулын 6-9 дүгээр сарын мэдээнд үндэслэн сум тус бүрээр ургамлын бүрхэвчийн зураглалыг хийж, бэлчээрийн газрын биомасс, даацыг тооцон аймгийн хэмжээнд элэгдэл, эвдрэл, доройтолд өртсөн газрыг тодорхойлж, үр дүнг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Сансрын болон хиймэл дагуулын зургийг ашиглан https://mongolia.sibelius-datacube.org/ сайтын тусламжтайгаар бэлчээрийн биомасс болон элэгдэл эвдрэлд орсон газрыг тодорхойлохоор боловсруулалтыг хийж байна. Боловсруулалтын үр дүнг хээрийн судалгааны ажлын үр дүнтэй харьцуулан 12 сарын 10-ны дотор хүргүүлнэ. | 90 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.8.**<br>**Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.** | | | | | | | |
| **1.8.1** | **Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг** | **Үйл ажиллагаа** | **Улсын хэмжээний тайлан** | **2018 онд Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг** | **Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах** | | | **шинэчлэн боловсруулж, батлуулсан.** | **удирдлагаар хангаж, явцыг жил бүр Засгийн газарт танилцуулсан байна.** | | |
| 1.8.1.1 | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн тайлан-1 | Засгийн газрын 2018 оны 384-р тогтоолоор Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдсан. | **Эхний хагас жилд:** Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг 1-р улиралд багтаан гаргаж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх 10 заалт бүхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг гарган байгууллагын 2024 оны 01/88 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 99%-ийн хэрэгжилттэйгээр тайлагнасан. | 100 |
| **1.8.2** | **Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах** | **Орон нутгийн төсөв** | **7 аймгийн болон нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө** | **12 аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.** | **Нийслэл, Булган, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Архангай, Баянхонгор, Ховд, Говь-Алтай аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна.** | | |
| 1.8.2.1 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх болон тодотгон боловсруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Дүгнэлтийн тоо | 18 аймгийн ГЗБЕТ (Говьсүмбэр, Увс, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Дундговь, Төв, Дархан-Уул, Дорноговь, Баян-Өлгий, Булган, Баянхонгор, Орхон, Архангай, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ) боловсруулсан. | **Эхний хагас жилд:** Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах үе шатуудад хяналт тавьж, үе шатны тайлангуудад дүгнэлт гарган гүйцэтгэгчид болон ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. **Жилийн эцэст:** Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийлгэхээр 74 сая төгрөгийг АИТХ-ын 2023 оны 20 дугаар тогтоолоор батлуулсан. Гүйцэтгэгчээр Ланд овнер ХХК шалгаран ажиллаж байгаа бөгөөд ажлын эхний үе шатны тайланг 07 дугаар сард ирүүлж аймгийн Засаг даргын 2024 оны А/178 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг тус тайлантай танилцан санал, дүгнэлт гаргаж Газрын даргын 2024 оны 01/277 тоот албан бичгээр Ланд овнер ХХК-д хүргүүлэн ажилласан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүрэн, зөв зурагласан эсэхэд хяналт тавьсан байна. ГЗБГЗЗЕГ-аас гаргасан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн засвар, өөрчлөлтийг гүйцэтгэгчээр хийлгэж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, батлуулах ажлыг зохион байгуулсан байна. | Тус санал, дүгнэлтийн дагуу тус компаниас одоог хүртэл хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг ирүүлээгүй байна. | |
| **1.8.3** | **Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **8 аймгийн болон нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө** | **12 аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.** | **Шинэчлэн боловсруулсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнг холбогдох аймгуудад хүргүүлсэн байна.** | | |
| 1.8.3.1 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах | Үйл ажиллагаа | Хэрэгжсэн арга хэмжээний тоо | 18 аймгийн ГЗБЕТ (Говьсүмбэр, Увс, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Дундговь, Төв, Дархан-Уул, Дорноговь, Баян-Өлгий, Булган, Баянхонгор, Орхон, Архангай, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ) боловсруулсан. | **Эхний хагас жилд:** Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудыг зохион байгуулсан байна. **Жилийн эцэст:** | 2017 онд орон нутгийн хөгжлийн сангийн 14,8 сая төгрөгөөр Лапланд Эко ХХК-иар “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-нд тодотгол хийлгүүлж, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 03 дугаар тогтоолоор хэлэлцүүлэн батлуулж тухайн төлөвлөгөөний хугацаа 2023 онд дууссан бөгөөд тус төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийхээр Ланд овнер ХХК-тай аймгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудыг зохион байгуулсан байна.<br>Хэрэгжилтийг 12 дугаар сарын 20-ны дотор тайлагнасан байна. | Тамгын газар гэрээ байгуулж төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. | |
| 1.8.3.2 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой мэдээ, судалгааг холбогдох байгууллагад хүргүүлэх | Үйл ажиллагаа | Судалгаа, мэдээллийн тоо | 18 аймгийн ГЗБЕТ (Говьсүмбэр, Увс, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Дундговь, Төв, Дархан-Уул, Дорноговь, Баян-Өлгий, Булган, Баянхонгор, Орхон, Архангай, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ) боловсруулсан.<br>175 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдсан. | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй холбоотой мэдээлэл, судалгааг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит хорьдугаар хуралдаанаар 2024 оны орон нутгийн төсөвт сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийлгүүлэхээр 93.2 сая.төгрөг, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийлгүүлэхээр 74.0 сая төгрөгийг тус тус батлуулсан бөгөөд дээрх ажлуудтай холбоотой мэдээллийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэн ажлын даалгаврыг ГЗБГЗЗЕГ-ын даргаар 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр батлуулсны дагуу тендерийг зарлагдаж, шалгаруулалт хийгдэн ажиллаж байна. | 100 |
| **1.8.4** | **Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах** | **Орон нутгийн төсөв** | **16 сум** | **98 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, баталгаажуулсан.** | **Жил бүр 18 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.** | | |
| 1.8.4.1 | Сумын нутаг дэвсгэрийн | Үйл ажиллагаа | Хэрэгжсэн арга | Улсын хэмжээнд 175 сумын нутаг | **Эхний хагас жилд:** | 2024 оны жилийн эцсийн байдлаар сумын нутаг дэвсгэрийн ерөнхий | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах. | | хэмжээний тоо | дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлагдсан. | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжих ажлуудыг зохион байгуулж ажилласан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжих ажлуудыг зохион байгуулж, цахим системд байршуулсан байна. Хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сард багтаан тайлагнасан байна. | төлөвлөгөө 85,8 сая төгрөгөөр хийгдэж байна.<br>Дээрх төлөвлөгөөг Ланд овнер ХХК нь хийж гүйцэтгэж байгаа бөгөөд төлөвлөгөө хийгдэж дууссаны үндсэн дээр арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ. | |
| 1.8.4.2 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах, тодотгох талаар аймаг, орон нутгийн удирдлагуудыг мэдээ, танилцуулгаар хангаж төлөвлөгөөний зардлыг төсөвт суулгах ажлыг зохион байгуулах | Үйл ажилллага а | Санхүүжил тын хэмжээ | - | **Эхний хагас жилд:**<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах болон тодотгоход шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт суулгуулах талаарх санал болон танилцуулгыг холбогдох албан тушаалтанд танилцуулах ажлыг зохион байгуулсан байна.<br>**Жилийн эцэст:** | Аймгийн 2024 оны төсөвт сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлын төсөв болох 93,2 сая төгрөгийг тусган батлуулсан.<br>Үүний үр дүнд Ланд овнер ХХК шалгаран ажил гүйцэтгэж, ажил хүлээлгэн өгөх шатандаа ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах болон тодотгоход шаардагдах зардлыг 2025 оны төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулж, батлуулсан байна. | | |
| 1.8.4.3 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах болон тодотгон боловсруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Дүгнэлтийн тоо | Улсын хэмжээнд 175 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлагдсан. | **Эхний хагас жилд:**<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, хянуулан батлуулсан байна.<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулж, төлөвлөгөө боловсруулах явцад хяналт тавьж, үе шат бүр дээр дүгнэлт гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах явцад хяналт тавьж, ГЗБГЗЗЕГ-аас гаргасан мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн засвар, өөрчлөлтийг гүйцэтгэгчээр хийлгэж, сумын ИТХ-аар | Байгууллагын 2024 оны 01/11 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний ажлын даалгаврыг боловсруулан батлуулахаар хүргүүлсэн.<br><br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний ажлын даалгаврын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр хянан баталгаажуулсны дагуу Ланд овнер ХХК шалгаран ажлын эхний үе шатны тайланг 2024 оны 07 дугаар сард ирүүлсэн. Тайлантай холбоотой санал, дүгнэлтийг байгууллагын 2024 оны 01/277 тоот албан бичгээр Ланд овнер ХХК-д хүргүүлэн ажилласан.<br><br>Дээрх санал, дүгнэлтийн дагуу тус компаниас 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр тайлан ирүүлсэн бөгөөд одоогийн байдлаар тайланг хянан үзэж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна. | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.13.<br>Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх замаар салбарын хэмжээнд цахим шилжилт хийх үйл ажиллагааг дэмжих** | | | | | | | |
| **1.13.2** | **Салбарын үйл ажиллагаанд цахим гарын үсэг болон тоон гарын үсэг нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа** | **85 тоон гарын үсэг** | **Салбарын хэмжээнд нийт 649 тоон гарын үсгийг шинэчлэн олгосон.** | **Газрын харилцааны салбарын нийт албан хаагчид тоон гарын үсэг ашигладаг болсон байна.** | | |
| 1.13.2.1 | Тоон гарын үсгийн олголт хийх, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах боломжийг нэвтрүүлэх | Үйл ажиллагаа | - Тоон гарын үсэг эзэмшигчийн тоо<br>- Тоон гарын үсгийг ашиглаж буй үйл ажиллагааны тоо | Салбарын хэмжээнд нийт 649 тоон гарын үсгийг шинэчлэн олгосон. | - Тоон гарын үсгийн олголтыг шинэчлэн хийсэн байна.<br>- Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашигладаг болсон байна. | Байгууллагын хэмжээнд Tridumkey Client 1 ширхэг тоон гарын үсгийг хэвийн ажиллагаатай ашиглаж байна. Tridum key тоон гарын үсэгний ашиглалтын хугацаа дуусч, дахин 2 жилийн хугацаатайгаар 80000 төгрөгөөр сунгуулсан. Байгууллагын хэмжээнд 12 ширхэг токен тоон гарын үсгийн хугацаа дууссан тул шинэчлэхээр хураан авч байгууллагын 2024 оны 01/440 тоотоор 16 албан хаагчдад шинэчлэн авах хүсэлтээ өгөөд байна. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.14.<br>Төрийн архивын стандарт орчныг сайжруулах** | | | | | | | |
| **1.14.1** | **Төрийн архивыг цахимжуулах, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, цахим үйлчилгээг нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа** | **1764 хадгаламжийн нэгж** | **2022 онд Төрийн архивын 14879 хадгаламжийн нэгжийн баримтыг архивын цахим системд холбосон.** | **1764 хадгаламжийн нэгжийн баримтыг архивын цахим системд холбоно.** | | |
| 1.14.1.1 | Архивын баримтыг цахимжуулах, цахим мэдээллийн сан үүсгэх | Үйл ажиллагаа | Цахимжуулсан хадгаламжийн | 2023 оны байдлаар 150 хадгаламжийн нэгжийн хуудас баримт цахимжсан. | **Эхний хагас жилд:**<br>50 хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, | 2024 оны 100 баримт цахимжуулан archive2.gazar.gov.mn сайтанд бүртгэсэн. Нийт өссөн дүнгээр 250 нэгжийг архивлан цахимжуулаад | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэгжийн тоо | | байнгын үйл ажиллагааг хангахад ГЗБГЗЗЕГ-ын Салбарын архивын хэлтэстэй хамтран ажиллаж холбогдох зааварчилгаа авсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>50 хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагааг хангахад ГЗБГЗЗЕГ-ын Салбарын архивын хэлтэстэй хамтран ажиллаж холбогдох зааварчилгаа авсан байна. | байна. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.15.<br>Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах** | | | | | | | |
| **1.15.1** | **Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах, хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Зохион байгуулсан ажлын тоо** | **-** | **Төрийн болон албаны нууцыг хадгалж, хамгаалах талаарх ажлуудыг зохион байгуулсан байна.** | | |
| 1.15.1.1 | Төрийн болон албаны нууцыг хадгалж, хамгаалах, хяналт тавих, Нууц албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | 1 мэдээ,<br>1 тооллого | 2023 онд Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр явуулсан үйл ажиллагааны мэдээг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.<br>2023 онд Төрийн болон албаны нууцын тооллого хийж, дүн | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр 2024 онд хэрэгжүүлсэн ажлын мэдээг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор ТЕГ-ын орон нутаг дахь Тагнуулын газар, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр 2024 онд хэрэгжүүлсэн ажлын мэдээ, тооллогын тайланг нууцын 2024 оны Н/02, Н/03 тоот албан бичгээр гарган ГЗБГЗЗЕГ-т болон Тагнуулын Ерөнхий газрын Говьсүмбэр аймаг дахь хэлтэст хүргүүлэн ажилласан.<br><br>2024 оны жилийн эцсийн байдлаар нууцын эрхлэгчээр дамжуулан 6 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэдээг хугацаанд нь явуулсан. | Нууцын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, нууц баримттай танилцах иргэний итгэмжлэлийг шинэчлэх, нууцын баталгаа авах, нотлох лавлагаа гаргаж өгөх, гадаад улсад зорчих эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтний урьдчилсан мэдүүлгийг авах, шилжилт хөдөлгөөний мэдээллийг тус тус бүртгэлжүүлж, мэдээ тайланг ТЕГ-ын орон нутаг дахь Тагнуулын газар, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. Аймгийн ГХБХБГ-ын төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалтын үзлэг тооллого хийсэн байна. Тооллогын мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | дэвсгэр зургийг холбогдох байгууллагуудад имэйл хаягаар хүргүүлэн бүртгэл хөтлөн ажилласан байна. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.20.**<br>**Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн системийг бүрэн ашиглалтанд оруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.** | | | | | | | |
| **1.20.1** | **Инженерийн дэд бүтэцтэй холбоотой мэдээллийг Хот байгуулалтын кадастрын** | **Үйл ажиллагаа** | **Инженерийн дэд бүтцийн мэдээлэл** | **-** | **Төлөвлөлтийн инженерийн дэд бүтэц, бэлтгэл ажлын мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **мэдээллийн санд бүртгэх** | | | | **системд бүртгэсэн байна.** | | |
| 1.20.1.1 | Инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээний орон зайн тоон зургийг холбогдох хангагч, ашиглалт хариуцсан байгууллагатай хамтран баяжилт хийх, мэдээллийг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөлтийн 7 давхаргын мэдээлэл | - | Аймгийн хэмжээнд Хот байгуулалтын кадастрын системд төлөвлөлтийн 7 давхаргын мэдээллийг бүртгэсэн байна. | 2024 онд шинээр ашиглалтад оруулсан цахилгаан хангамжийн 9, барилга угсралтын 2 ажлын гүйцэтгэлийн зургийг холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэснийг хүлээн авч, мэдээллийн санд баяжуулалт хийн ажилласан.<br>- Хот байгуулалтын кадастрын мэдээллийн цахим системд аймгийн хэмжээнд нийт нийт 305 барилга байгууламж, 10 дурсгалын хөшөө, баримал, 1816м дугуйн зам, 7025м явган хүний зам, 298561м2 ногоон байгууламжийн талбай, 5 усан оргилуур, 6 оршуулгын газар, 25617.37м ус хангамжийн шугам, 9546м дулаан хангамжийн шугам, цахилгаан 7453м, 12506,27м ариутгах татуургын шугамын мэдээлэлийн бүрдүүлэлттэй байна. | 90 |
| **1.20.2** | **Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг танилцуулах, сурталчилах** | **Үйл ажиллагаа** | **2 арга хэмжээг авч хэрэгжүүлэх** | **-** | **Хот байгуулалтын кадастрын мэдээллийн нэгдсэн системийг сурталчилсан байна.** | | |
| 1.20.2.1 | Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчилах | Үйл ажиллагаа | 4 арга хэмжээ | - | **Эхний хагас жилд:**.<br>Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчлах чиглэлээр 2 арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Хот байгуулалтын кадастрын цахим | 1. Хот байгуулалтын кадастрын urban.gov.mn цахим системд 11 удаа байршуулан иргэд олон нийтийг мэдээллээр хантан ажиллаж байна. Үүнд:<br>- Барилга байгууламж шинээр барих - архитектур төлөвлөлтийн даалгавар олгох хүсэлт илгээх,<br>- Барилгын загвар зураг батлах хүсэлт илгээх, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | системийг олон нийтэд сурталчлах чиглэлээр 2 арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлсэн байна. | - Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ шинээр олгох хүсэлт илгээх заавар видео болон цахимаар хүсэлт илгээхэд шаардлагатай материалын мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим хуудас болон пэйж хуудсуудад | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.21.<br>Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| **1.21.1** | **Аймгийн хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх** | **Үйл ажиллагаа** | **Хэрэгжилтийн хувь** | **-** | **Газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон газрын төлөв байдал, чанарын хянан магадлагааны хэрэгжилтийг 80%-д хүргэсэн байна.** | | |
| 1.21.1.1 | Аймгийн хэмжээнд газар, геодези, зураг зүйн чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 10 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан | - Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 576 объектод төлөвлөгөөт шалгалт хийхээр “Хяналт шалгалтын төлөвлөгөөг” Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>- Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 74 дүгээр тушаалаар батлуулсан. | Шалгалтаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт объектын эрсдэлийн түвшинг бууруулсан байна. Хяналтын хуудсаар илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 35-00/03 тоот төлөвлөгөөт шалгалт хийх удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд 10 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2024 оны 05 дугаар сарын 15-аас 10 дугаар сарын 18-ны өдрийн дотор 9 объектод шалгалт хийлээ. Энэ оны жилийн эцсийн байдлаар Хан-Аттрибут ХХК нь үйл ажиллагаа явуулаагүй тул төлөвлөгөөт шалгалт хийгдээгүй болно. Шалгалтанд хамрагдсан 9 обьект бага эрсдэлтэй үнэлэгдэж, аймгийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээ дунджаар 18,92 хувь, хууль сахин мөрдөлт 81,08 хувьтай байна. Төлөвлөгөөт шалгалтын хүрээнд 2 хуулийн этгээдэд 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн. Тухайн албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн хуулийн этгээдэд гүйцэтгэлийн шалгалт хийж зөрчлийг арилгуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | объектын тоо, хувь | | | Шалгалтын хүрээнд 1 хуулийн этгээдийг 5 сая төгрөгийн торгууль ногдуулан төлүүлж, зөрчлийг арилгав. | |
| 1.21.1.2 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн “Газрын кадастрын цахим систем”-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх. | Үйл ажиллагаа | Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо, гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн “Газрын кадастрын цахим систем”-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт хийх, дүгнэлт гаргах, авах арга хэмжээний саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийн дагуу цахим системд үүсгэсэн хувийн хэргийн 1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын хувийн бүрдүүлэлтэд хяналт хийсэн. | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Шалгалтын дүнг хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 35-00/08 тоот Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн “Газрын кадастрын цахим систем”-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд түүвэрлэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 09 дүгээр сарын 01-ны өдрийн дотор нийт 54 нэгж талбарт хийхэд 14 нэгж талбарын бүрдүүлэлт дутуу хангалтгүй байлаа. Үүнд: Баянтал суманд 10 нэгж талбар, Шивээговь суманд 4 нэгж талбар байлаа. Дээрх цахим хувийн хэргийн бүрдүүлэлтийг хариуцсан газрын даамал нараар зөрчлийг арилгуулж ажилласан. | 100 |
| 1.2.1.3 | Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн | Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 35-00/11 тоот гүйцэтгэлийн шалгалт хийх удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд геодези, зураг зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Климаксреферэнс ХХК-ийг шалгалтанд хамруулсан. Геодези, зураг зүйн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас /35.5/-аар шалгахад хууль сахин мөрдөлтийн хувь 82.65, эрсдэл үүсэх магадлал 17.35 буюу бага эрсдэлтэй үнэлэгдлээ. Мөн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны тайлан, дүгнэлтийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | түвшин буурсан объектын тоо | | биелэлтийг бүрэн хангуулсан байна. | хянан үзэх маягтийг дагуу дүгнэхэд 25 онооноос 21.5 оноо авсан болно. Зөрчлийг арилгуулан ажилласан. | |
| 1.21.1.4 | Соёл, урлагийн байгууллагын газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлж, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | Газар, геодези, зураг зүйн салбарын улсын ерөнхий байцаагч, соёл салбарын улсын ерөнхий байцаагчийн хамтарсан урьдчилсан сэргийлэх 2024 оны 35-00/06, 05-00-00-001/07 шалгалтын удирдамжийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 30-31-ны өдрүүдэд аймгийн Соёлын хяналтын улсын ахлах байцаагч Б.Энхтөрийн хамт Баянтал, Сүмбэр, Шивээговь сумдын 8 байгууллагад дээр очиж шалгалтыг хийлээ.Шалгалтанд хамрагдсан 2 хуулийн этгээд өөрийн эзэмшил газаргүй, өөр төрийн байгууллагын байранд байрлаж байсан. Шалгалтанд хамрагдсан хуулийн этгээдийг хяналтын хуудсаар үнэлэхэд аймгийн хэмжээнд дунджаар эрсдэл үүсэх магадлал 9.16, хууль сахин мөрдөлтийн дундаж хувь 90.84-тай байсан. Шалгалтанд хамрагдсан 8 байгууллагаас 3 байгууллагад зөвлөмж хүргүүлж, гүйцэтгэлийн шалгалтыг 2024 оны 10 дугаар сарын 14-ны өдрүүдэд хийхэд эрсдэл үүсэх магадлал 8.62, хууль сахин мөрдөлтийн дундаж хувь 91.38-тай байна. | 100 |
| 1.21.1.5 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд зөрчилтэй бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдийн газар эзэмшил, | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн | Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 35-00/05 тоот урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд зөрчилтэй бүртгэгдсэн 168 иргэн, хуулийн этгээдийн судалгааг аймгийн хэмжээнд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах | | улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | | арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | Газрын удирдлагын хэлтсийн кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн О.Энхзултай хамтран гаргасан. Уг судалгааг сумдаар ангилбал Баянтал суманд 17, Сүмбэр суманд 126, Шивээговь суманд 25 иргэн, хуулийн этгээд тус тус цахим системд газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан гэж бүртгэгдсэн байна. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд зөрчилтэй бүртгэгдсэн 2 хуулийн этгээд, 17 иргэнд нийт 18.5 сая төгрөгний зөрчлийг хэргийг хялбаршуулсан журмын дагуу шийдвэрлэн, аймгийн торгуулийн дансанд төвлөрүүлсэн. Нийт 37 иргэн, хуулийн этгээдийн газар эрхийн гэрчилгээний хугацаа дууссан зөрчлөө арилган, 15 иргэн, хуулийн этгээд зөрчлөө арилган шийдвэрлэх шатандаа явж байна. Харин нь мэдээллийн санд газар эзэмших гэрээний хугацааг буруу оруулсан 1, эзэмшиж буй газраа бусдад руу шилжүүлсэн байтал мэдээллийн санд өөрчлөлтийг хийлгэх 2 иргэний мэдээллийг илрүүлэн хариуцсан мэргэжилтэн, газрын даамал нартай хамтран ажиллаж зөрчлийг арилгав. | 90 |
| 1.21.1.6 | Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн нэгж талбарын цахим системд үүсгэсэн хувийн хэргийн бүрдүүлэлтэд гүйцэтгэлийн хяналт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан | 2023 онд Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн “Газрын кадастрын цахим систем”-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт хийх, дүгнэлт гаргах, авах арга хэмжээний | **Эхний хагас жилд:** Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга | Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 35-00/11 дугаартай гүйцэтгэлийн шалгалт хийх удирдамжийн дагуу өмнөх шалгалтаар илэрсэн 17 нэгж талбарын цахим системд үүсгэсэн хувийн хэргийн бүрдүүлэлтэд 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн О.Энхзултай хамтран зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийн дагуу цахим системд үүсгэсэн хувийн хэргийн 1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын хувийн бүрдүүлэлтэд хяналт хийсэн. | хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | байгуулж, хариуцсан сумдын газрын даамал нарт гүйцэтгэлийн шалгалт хийхэд бүрэн зөрчилгүй болсон байна. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.22.**<br>**Хүн амын нутагшилт, суурьшлийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | | | |
| **1.22.2** | **Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох** | **Үйл ажиллагаа** | ***Жил бүр 5-аас доошгүй эрх зүйн акт*** | **Жил бүр 10 орчим эрх зүйн акт боловсруулж байна.** | **Нийт эрх зүйн актын 10 орчим хувийг шинэчилсэн байна.** | | |
| 1.22.2.1 | Нийтээр болон салбарын хэмжээнд дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөх | Үйл ажиллагаа | Санал өгсөн төслийн тоо | 2022 онд улсын хэмжээнд 6 норм, дүрэм, 5 стандарт, 12 журам, 3 заавварт санал өгсөн. | Нийтээр болон салбарын хэмжээнд дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгсөн байна. | Байгууллагын 2024 оны 01/42, 01/50, 01/108 тоот албан бичгүүдээр санал хүргүүлсэн. Үүнд:<br>• Хот байгуулалтын цахим системд нэмэлт хөгжүүлэлт оруулах санал;<br>• Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын төсөлд санал;<br>• Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх журам болон арга зүйг сайжруулах санал<br>• Нэгж талбарын хувийн хэрэг хөтлөх журмыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаарх санал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.2.2 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, төлөвлөх ажлын хүрээнд газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр объектын эрсдэлийн үнэлгээ хийх | Үйл ажиллагаа | Эрсдэлийн үнэлгээг үнэлсэн байдал | 2023 онд улсын хэмжээнд 7035 объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн. | **Жилийн эцэст:** Эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр объектын эрсдэлийг үнэлэх ажлыг зохион байгуулсан байна. | Эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр объектын эрсдэлийг үнлэх цахим системээр 18 обьектийг үнэллэж ажилласан. Үүнээс их эрсдэлтэй үнэлэгдсэн 1 обьект, дунд эрсдэлтэй 17 обьект үнэлэгдсэн болно. | 100 |
| 1.22.2.3 | Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулсан байдал | Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 74 дүгээр тушаалаар 2023 онд улсын хэмжээнд 367 объектод хяналт шалгалт хийсэн. | **Жилийн эцэст:** Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг Засгийн газраар батлуулахад санал өгч, ГЗБГЗЗЕГ-тай хамтран ажилласан байна. | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын хяналт шалгалтын хэлтсээс 2025 онд аялал жуулчлал, шатахуун түгээх станцын чиглэлээр шалгах чиглэл өгсний дагуу 11 обьектын судалгааг гарган цахим хаяг /аймаг-ерөнхий газар-байцаагч нар/аар газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас батлуулахаар хүргүүлсэн | 100 |
| **1.22.5** | **“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Салбарын хэмжээнд 4761 мод** | **2021 онд ГЗБГЗЗГ, Нийслэлийн ГЗБА, 21 аймгийн ГХБХБГ нийт 3862 мод тарьсан.** | **“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулж, салбарын хэмжээнд тайланг нэгтгэн гаргасан байна.** | | |
| 1.22.5.1 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | 110 ш мод | 2023 онд тус салбарын хэмжээнд хавар нийт 1886 мод тарьсанаас 1635 мод ургаж байна. | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулж, тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд манай байгууллага 2024 оны байдлаар нийт 160 ширхэг хайлаас модыг Ойн ангийн мод үржүүлгийн талбайд 320,000 төгрөгийн зардлаар тарьж, арчилж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.5.2 | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зориулалтаар газар эзэмшүүлэх байршлыг тодорхойлж газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангуулах | Үйл ажиллагаа | Иргэн, аж хуйн нэгж, байгууллагад Мод ургжүүлгийн зориулалтаар олгосон газрын тоо, хэмжээ | - | Шинээр тарьж, арчилж ургуулсан ой, модоор бүрхэгдсэн болон тохижилт хийсэн цэцэрлэгт хүрээлэн, гудамжны талбайн хэмжээ нэмэгдсэн байна. | Жил бүр ногоон байгууламжийг нэмэгдүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. 2024 оны байдлаар 6 байршилд мод ургжүүлэг болон соёл амралтын хүрээлэнгийн зориулалтаар 27 га газрыг олгон ажиллаад байна. Үүнд: ϖ Соёл амралтын хүрээлэнгийн зориулалтаар 4 байршилд 24 га ϖ Мод ургжүүлэгийн зориулалтаар 1 байршилд 3га тус тус газар олголтыг хийсэн. | 100 |
| **1.22.6** | **“Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнд оролцох** | **Үйл ажиллагаа** | **Хэрэгжүүлсэн арга хэмжээ** | **Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан.** | **“Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон байна.** | | |
| 1.22.6.1 | “Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жилийн хүрээнд аймгийн хэмжээнд төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах | Үйл ажиллагаа | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/05 дугаар тушаалаар 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жил болгон зарласан. | Нэрэмжит жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | “Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жилийн хүрээнд аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Газрын даргаар 2024.03.20-ний өдөр баталуулж 39 арга хэмжээг төлөвлөж төлөвлөгөөний биелэлтийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай биелсэн байна. | 90 |

**ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж** | | | | | | |
| **2.1.2** | **Том масштабын байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн сангийн баяжуулалт, үйлчилгээ** | **Үйл ажиллагаа** | **Байр зүйн тоон зураг, шугам сүлжээний мэдээллийн сангийн цахим үйлчилгээгээр хэрэглэгч байгууллага, иргэдийг хангах** | **Байр зүйн тоон зураг, инженерийн шугам сүлжээний мэдээллийн санг хөтлөх журам батлагдсан.**<br>**Байр зүйн тоон зураг, шугам сүлжээний мэдээллийн санг цахимаар шинэчлэх боломж бүрдсэн.** | **21 аймаг, нийслэлийн 1:1000-ны масштатбай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зургийн мэдээллийн сангийн шинэчлэлтийг хөтөлсөн байна.** | | |
| 2.1.2.1 | Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодези, зураг зүйн ажлыг шалгаж хүлээн авах | Үйл ажиллагаа | Геодези, зураг зүйн ажлын үр дүн ирүүлсэн хүсэлтийн тоо | 2023 онд AAH-ийн ирүүлсэн хүсэлтэд хяналт хийж, дүгнэлтээр AMX-д хүлээлгэн өгсөн. | Хүсэлт ирсэн тухай бүрд ажлыг шалгаж, үр дүнг хүлээн авч геопорталд мэдээллийг оруулж, хэрэглээнд гаргасан байна. | 2024 онд нийт 8 ажлын гүйцэтгэлийн зураглалыг хянаж, засварлуулан хүлээн авсан. Үүнд:<br>➢ Өлзийт суурьшлын бүсийн гадна цахилгаан хангамжийн ажил<br>➢ Наран шинэ суурьшлын бүсэд цахилгаан татах ажлыг зураглал дээр далан болон авто зам, фойнтыг тэмдэглээгүй байсныг засварлуулсан.<br>➢ Сүмбэр сумын 2-р багт Халуун усны барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэн гүйцэтгэлийн зураглалыг Гео тана сүрвэй XXK хийж гүйцэтгэсэн.<br>➢ Бурхант суурьшлын бүсэд цахилгаан татах ажлыг Эрчим сансар XXK хийж гүйцэтгэж гүйцэтгэлийн зураглалыг Шинэ геодези XXK нь хийж гүйцэтгэсэн.<br>➢ Аймгийн төвийн бохирын шугамыг нэмэгдүүлэх сайжруулах ажлыг Одкон холдинг XXK гүйцэтгэж, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гүйцэтгэлийн зураглалыг Төв тэгш хэм ХХК хийж гүйцэтгэсэн.<br>➢ Шивээговь сумын 150 ортой цэцэрлэгийн барилгын гүйцэтгэлийн зураглалыг Талст газар ХХК хийсэн.<br>➢ Тагтын эгнээнд ухаалаг худаг, цэвэр усны шугамыг Такамаса ХХК хийж гүйцэтгэн, гүйцэтгэлийн зураглалыг Талст газар ХХК хийсэн.<br>➢ МСҮТ-ийн урд уулзвараас төв зам хүртлэх авто замын гэрэлтүүлэгийн ажлыг Нуклон ХХК хийж гүйцэтгэн, гүйцэтгэлийн зураглалыг Геокоординат ХХК хийсэн.<br>Дээрх гүйцэтгэлийн зураглалын холбогдох алдаануудыг засварлуулан хүлээн авч www.urban.gov.mn цахим сайтанд оруулан ажилласан. | |
| **2.1.3** | **Статик хэмжилтийн тэгшитгэн бодолтын онлайн боловсруулалтын системийн үйл ажиллагаа** | **Үйл ажиллагаа** | **1 систем** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн.** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээнд тулгуурлан статик хэмжилтийн тэгшитгэн бодолт хийдэг онлайн боловсруулалтын системийн хэвийн ажиллагааг хангасан байна. Ази-Номхон далайн бүсийн геодезийн ажлын группд Монгол Улсын 6 GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын хэмжилтийн өгөгдлийг бэлтгэн илгээсэн байна.** | | |
| 2.1.3.1 | Геодезийн сүлжээний цэгийн солбицлыг | Үйл ажиллагаа | 1 цэг | Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолоор ITRF2020 | **Эхний хагас жилд:** Аймгийн төвд байрлах гравиметрийн | Улсын хэмжээнд ITRF2020 тогтолцоонд шилжиж байгаатай холбогдуулан 2024 оны 01 сарын 24-ний өдөр Баянтал сумын GR02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжүүлэх судалгаа хийх | | | солбицлын тогтолцоог ашиглахаар болсон. | сүлжээний цэг дээр GNSS-ийн 12 цагийн хэмжилт хийж өгөгдлийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | цэг дээр RTK хэмжилтийг хийн үр дүнг 192.168.20.24 шэйрд байрлууж мэдээг дамжуулсан. | |
| **2.1.5** | **Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг шинэчлэх** | **Үйл ажиллагаа** | **GNSS-ийн дэд болон зураглалын сүлжээ 200 цэг, тэмдэг** | **Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2022 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн.** | **Цэг, тэмдэгтийн цахим санг хөтөлж, шаардлагатай цэг, тэмдэгтийг нөхөн сэргээсэн байна.** | | |
| 2.1.5.1 | Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн цахим санг шинэчлэх | Үйл ажиллагаа | GNSS-ийн дэд болон зураглалын сүлжээний цэг, тэмдэгт | Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2023 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн. | Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодезийн ажлын цэг, тэмдэгтийн мэдээллээр геодезийн цахим сангийн шинэчлэлтийг хөтөлсөн байна. | 2023 онд Сүмбэр сумын орон нутгийн хөгжил сангийн 8’0 сая төгрөгийн төсвөөр Климакс референс ХХК-иар геодезийн 4 цэг тэмдэгтийг шинээр болон нөхөн сэргээлт хийлгэсэн. Дээрх цэг тэмдэгтийн мэдээллийг Геопорталд 2023 оны 09 дүгээр сард оруулан цахим системийг шинэчлэн ажилласан. | 100 |
| 2.1.5.2 | Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Нөхөн сэргээсэн цэгийн тоо | 2019 онд Газрын даргын А/291 дугаар тушаалаар “Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, нүүлгэн шилжүүлэх” журмыг баталсан. | Цэг, тэмдэгт нөхөн сэргээсэн ажлын үр дүнг хүлээн авч, цэг, тэмдэгтийн мэдээллийг цахим санд оруулсан байна. | Аймгийн хэмжээнд геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллогын ажлыг зохион байгуулсан тайлан, мэдээг байгууллагын 2024 оны 01/387 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэн ажилласан.<br>Мөн цэг, тэмдэгтийн тооллогоор устсан цэг тэмдэгтийг нөхөн сэргээх зардлын тооцоог гарган сумдын Засаг дарга нарт 2025 оны орон нутгийн төсөвт тусгуулах тухай албан тоотыг байгууллагын 2024 оны 01/377, 01/378, 01/379 тоот бичгээр хүргүүлэн ажилласан. | 100 |
| **2.1.6** | **Хаягийн мэдээллийн системийг хөтлөх** | **Үйл ажиллагаа** | **Хаягийн мэдээллийн сангийн** | **Хаягийн мэдээллийн санг нэвтрүүлсэн.** | **Хаягийн мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна.** | | |

| | | | үйл ажиллагаа | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.6.1 | Нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулсан гудамж, зам болон нэрэмжит болгосон талбайг мэдээллийн санд бүртгэх | Үйл ажиллагаа | Гудамж, замын тоо | Хаягийн мэдээллийн систем | Нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох ажлыг аймгийн ерөнхий архитектортай хамтран аймгийн хэмжээнд зохион байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулж, нэр олгогдсон, нэрэмжит болгосон талбай, гудамж, замыг хаягийн мэдээллийн санд бүртгэсэн байна. | 2023 онд Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 05 дугаар тогтоолоор Сүмбэр сумын хэмжээнд шинээр бий болсон 5 авто замын гудамжны нэршлийг баталсан.<br>Дээрх тогтоолын дагуу хаягийн мэдээллийн санд гудамжийг зураглан оруулж иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шинэ хаягаар үйлчилгээ үзүүлж байна.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам талбай байхгүй болно. | 100 |
| 2.1.6.2 | Кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй боловч хаяг олгогдоогүй нэгж талбарт Хаягийн мэдээллийн системээр хаяг олгож, баталгаажуулах, тус системийг үйл ажиллагаандаа тогтмол ашиглах | Үйл ажиллагаа | Гудамж, замын тоо | Хаягийн мэдээллийн систем | Хаяг олгогдоогүй нэгж талбаруудад хаяг олгож баталгаажуулсан байна | Аймгийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 95 нэгж талбарт шинэчлэгдсэн хаягаар хаяг олгон ажилласан. | 100 |
| 2.1.6.3 | Хаягийн өгөгдөл мэдээллийг засварлах, шинэчлэн зураглах ажлын даалгаврын дагуу Хаягийн мэдээллийн систем дэх | Үйл ажиллагаа | Зам, гудамж, орц гарц, гудамжны эхлэл, төгсгөлийн тоо | Хаягийн мэдээллийн систем | **Жилийн эцэст:**<br>Батлагдсан ажлын даалгаврын дагуу Хаягийн мэдээллийн систем дэх алдаатай өгөгдөл мэдээллийг засварласан байна. | Аймгийн хэмжээнд 2017-2020 хооронд нийт 87.5 сая төгрөгийн төсвөөр 3652 ширхэг тэмдэгийг хийлгэн байршуулж, гудамж, зам талбайг зураглах, нэгж талбар, барилгад хаяг олгох, засварлах ажлыг 2021 оноос эхлэн хаягийн мэдээллийн санд оруулан ажиллаж байгаа бөгөөд 2024 оны байдлаар 95 нэгж талбарын хаягийг мэдээллийн санд шинэчлэн оруулаад байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | алдаатай өгөгдөл мэдээг засварлах | | | | | | |
| 2.1.7 | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржтэй холбоотой үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих** | **Үйл ажиллагаа, ургалт төсөв** | **Нийслэл, 21 аймаг** | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржийн системийг нэвтрүүлсэн.** | **Газрын үнэлгээ, төлбөр, татвар, газрын биржтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.** | | |
| 2.1.7.1 | Газрын төлбөр, татварын ногдуулалтыг Татварын удирдлагын нэгдсэн системд илгээх, уг системээс газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээллийг хүлээх авах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн, системээс төлөлтийн мэдээлэл хүлээн авсан нэгж талбарын тоо | Газрын төлбөр, татварын систем | Хуульд заасан хугацаанд төлбөр, татварын ногдуулалтыг илгээх, төлөлтийн мэдээллийг тухай бүр хүлээж авсан байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар газрын төлбөрийн системээр дамжуулан Газрын кадастрын цахим системд бүртгэлтэй хүчинтэй гэрээг үндэслэн нийт 11112 нэгж талбарт татвар, төлбөрийн ногдуулалтыг үүсгэж татварын системд илгээж ажилласан. Үүнд:<br>- 1987 нэгж талбарт газрын төлбөрийн ногдуулалт<br>- 9125 нэгж талбарт газрын татварын ногдуулалт үүсгэсэн.<br>Үр дүн: 2024 оны 11 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар 272,079 сая төгрөгийн төлбөрийг төвлөрүүлсэн байна. | 100 |
| 2.1.7.2 | Төлбөрийн даалгавар үүсгэн тэмдэгтийн хураамж, хураамжийн ногдуулалтыг хийж Татварын удирдлагын нэгдсэн системд илгээх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Эрхийн харилцаанд орж байгаа нэгж талбарын тоо | Газрын төлбөр, татварын систем | Үйлчилгээ үзүүлсэн тоогоор тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийн төлбөрийн даалгавар үүсгэсэн байна. | Аймгийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар газрын кадастрын мэдээллийн сангийн вэб системийн тусламжтайгаар нийт 194 төлбөрийн даалгавар үүсгэн холбогдох дансанд тушаалган ажилласан. Үүнд:<br>✓ Сүмбэр сум-169 ИААНБ<br>✓ Баянтал сум-16 ИААНБ<br>✓ Шивээговь сум-9 ИААНБ<br>Улсын хэмжээнд газартай холбоотой өргөдөл, хүсэлтийг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн цахимаар авдаг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болсонтой холбогдуулан улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн даалгаврыг шинээр болон байгууллага дээр ирж цахимаар хүсэлт илгээж байгаа иргэн, хуулийн этгээдээр улсын тэмдэгтийн хураамжийг төлүүлэн ажиллаж байгаа болно. | |
| 2.1.7.3 | Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөлт хийх бүх боломжуудын талаар иргэд, олон нийтэд сурталчлах | Үйл ажиллагаа | Цахим системийн хэрэглээ | Газрын төлбөр, татварын систем | **Эхний хагас жилд:** Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөх боломжийг сурталчилсан байна. | Байгууллагын цахим сайт болох govisumber.gazar.gov.mn сайт болон фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан egazar.gov.mn сайт, багийн өдөрлөгүүд, Нээлттэй хаалганы өдөрлөгөөр иргэдэд газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөлт боломжтой талаар иргэд, олон нийтэд сурталчлах мэдээллэж давхардсан тоогоор 388 иргэдэд мэдээлэн ажилласан. | 100 |
| 2.1.7.4 | Газрын зах зээлийн үнийн мэдээллийг Газрын үнэлгээний системд оруулах, масс үнэлгээ хийх | Үйл ажиллагаа | Газрын зах зээлийн үнийн мэдээллийн тоо | Газрын үнэлгээний систем | **Эхний хагас жилд:** Хот, тосгон, бусад суурин газрын зах зээлийн үнийн мэдээллийг оруулсан байна. **Жилийн эцэст:** Бүртгэсэн зах зээлийн үнийн мэдээллийг ашиглан масс үнэлгээ хийсэн байна. | Газрын үнэлгээний цахим системд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг өмнө онд 1170 мэдээ оруулсан бол энэ оны байдлаар 1322 мэдээ оруулсан байна. Үүнээс Аймгийн төв 61, Сүмбэр сум 31, Баянтал сум 30, Шивээговь сум 30 мэдээ оруулж ажиллаад байна. | 100 |
| 2.1.7.5 | Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн болон нөхөх олговроор олгосон, чөлөөлсөн талаарх өгөгдөл | Үйл ажиллагаа | Газрын зах зээлийн үнийн мэдээллийн тоо | Газрын үнэлгээний систем | **Эхний хагас жилд:** Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны үнэ, дуудлага худалдааны анхны үнэ төлсөн болон нөхөх олговроор олгосон, чөлөөлсөн талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулан боловсруулалт хийж, | ГЗБГЗЗЕГ-аас ирүүлсэн 2024 оны 1/1045 дугаар тоот албан бичгийн дагуу судалгаа мэдээллийг байгууллагын 2024 оны 02/146 дугаар тоот албан бичгээр хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг цуглуулан боловсруулалт хийж, мэдээллийн сан үүсгэх; | | | | мэдээллийн сан үүсгэж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | | |
| 2.1.7.6 | Газрын биржийн цахим системээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбарын тоо | Газрын биржийн цахим системээр зохион байгуулах боломж бүрдсэн. | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан газарт дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулсан байна. | Аймгийн хэмжээнд Засгийн газрын 2024 оны 136, 31 дүгээр тоот тогтоолын дагуу 19 байршилд 39,8 га газарт дуудлага худалдаа зохион байгуулагдахаас 13 байршилд дуудлага худалдаа зохион байгуулагдсан. 6 дуудлага худалдаа зохион байгуулагдахаар цахим биржид зарлаад байна.<br>Төсөл сонгон шалгаруулалтыг аймгийн хэмжээнд 3455,1 га газарт мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар олгохоор төлөвлөснөөс 17 малчдын хоршоонд 61,5 га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар олгож ажиллаад байна.<br>Мөн үйлдвэр технолгийн паркын зориулалтаар 3379,80 га газрын төсөл сонгон шалгаруулалт зарлагдан ажиллаж байна. | 100 |
| 2.1.7.7 | Газрын биржийн цахим програм хангамжаар дамжуулан газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах, олон нийтэд үйлчлэх | Үйл ажиллагаа | Эрх шилжсэн нэгж талбарын тоогоор үнийн мэдээ нэмж бүртгэнэ. | Газрын биржийн цахим системд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ бүртгэх боломжтой болсон. | Газрын эрх шилжсэн нэгж талбарын тоогоор газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээг Газрын биржийн цахим системд бүртгэсэн байна. | Худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газраа шилжүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газрын үнийн мэдээг тухай бүрд нь бүртгэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийт 450 нэгж талбарын эрх шилжих хөдөлгөөн хийгдснээс 2024 оны байдлаар:<br>- Сүмбэр- 400<br>- Шивээговь- 25<br>- Баянтал- 25<br>Тус газрын зах зээлийн үнийн мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлэл хүргэн ажиллаж байна.<br>**Үр дүн:** Иргэд газрын зах зээлийн үнийг цахимаар авах боломжтой бөгөөд газрын үнэлгээний суурь үнийг тооцоолоход хялбар болсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.8** | **Газрын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Газрын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаа** | **Газрын кадастрын мэдээллийн санг нэвтрүүлсэн.** | **Газрын кадастрын мэдээллийн санг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.** | | |
| 2.1.8.1 | Сумдын газрын даамлуудын өмнөх онуудад үүсгэсэн нэгж талбарын хувийн хэрэгт хяналт шалгалт хийж, илэрсэн алдаа дутагдалыг арилгах, сайжруулах, нөхөн бүрдүүлэх, цэгцлэх, ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Засварлагдсан нэгж талбарын хувийн хэргийн тоо | Нэгж талбарын хувийн хэргийн тоо | Нэгж талбарын хувийн хэрэгт холбогдох журмын дагуу хяналт хийгдэж алдаа, дутагдал заварлагдаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Сумдын газрын даамлуудын өмнөх онуудад үүсгэсэн нэгж талбаруудаас 18 нэгж талбарт хавсралт материалыг буруу оруулсныг засварлан ажилласан. Мөн 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр сумдын газрын даамлуудын ажиллах ур чадварыг дээшлүүлэх, сайжруулах, нэгж талбарын хувийн хэргийн бүрдэлийг хангах талаар хугацаатай үүрэг өгч ажилласан.<br>Дээрх тайлан мэдээг ГЗБГЗЗЕГ-т байгууллагын 2024 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн 01/199 дугаар тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан. | 100 |
| 2.1.8.2 | Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн цахим архивын материалд хяналт шалгалт хийж, илэрсэн алдаа дутагдалыг арилгах, сайжруулах, нэгж талбарын хувийн хэргийн бүрдлийн дагуу цахим хавсралтыг баяжуулах арга | Үйл ажиллагаа | Засварлаж сайжруулсан цахим хавсралтын тоо | Системд бүртгэгдсэн өргөдлийн тоо | ГКМС-ийн өргөдлийн цахим хавсралтад хяналт шалгалт хийгдэж алдаа дутагдал засварлагдаж, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн өргөдлүүдээс түүвэрчилсэн байдлаар нийт 51 өргөдлийн цахим хавсралт материалт хяналт шалгалтыг хийн ажилласан. Үүнд:<br>• Сүмбэр сум-25<br>• Баянтал сум-18<br>• Шивээговь сум-8<br>Дээрх өргөдөл бүртгэлээс 18 нэгж талбарын хавсралт файл зөрчилтэй байсныг холбогдох мэргэжилтнүүдээр засварлуулан ажилласан бөгөөд тайлан мэдээг ГЗБГЗЗЕГ-т байгууллагын 2024 оны 01/199 дугаар тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээг зохион байгуулах | | | | | Мөн байгууллагын даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан сумдын газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналт тавих ажлын удирдамжийн дагуу 2024 оны 11 дүгээр сайран 27-ны өдөр Шивээговь суманд шалгалт хийж ажилласан. Энэхүү хяналт шалгалтын хүрээнд Шивээговь суманд ГКМС-д үүссэн өргөдлийн хавсралтыг түүвэрлэн 20 нэгж талбарыг шалгаж үзэхэд 1 нэгж талбарын хавсралтын бүрдэл хэсэгт дутагдал гарсаныг засварлуулан ажилласан байна. | |
| 2.1.8.3 | Газрын нэгдсэн цахим систем egazar.gov.mn-ийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилах, танилцуулах аргах хэмжээг зохион байгуулах, орон нутагт цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх | Үйл ажиллагаа | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Газрын нэгдсэн цахим систем /egazar.gov.mn/ | Цахим системийн хэрэглээ нэмэгдэж иргэд олон нийт Egazar.gov.mn хаягаас газартай холбоотой мэдээ, мэдээлал авах, цахимаар хүсэлт илгээдэг болж цахимаар илгээх хүсэлтийн тоог нэмэгдүүлсэн байна | Байгууллагын даргаар 2024.04.03-ний өдөр Хариуцлагатай газрын харилцаа 2 сарын аяны төлөвлөгөөг батлуулж 26 арга хэмжээг төлөвлөж батлуулсан.<br>Энэхүү ажлын хүрээнд 32 төр, хувийн хэвшлийн байгууллагад, хөдөөгийн багийн 150 орчим иргэдэд мэдээ мэдээллийг хүргэж өгарын авлага тараасан.<br>Үүний үр дүнд 2024 оны байдлаар газрын кадастрын цахим системд нийт 995 цахим хүсэлт ирсний 373 нь 2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан гэр бүлийн хэрэгцээнд үнэ төлбөргүй газар эзэмших хүсэлт бөгөөд үлдсэн 622 нь эрх шилжүүлэх, барьцаанд бүртгүүлэх, хугацаа сунгуулах, нэгтгэх, хуваах өргөдлийн төрлүүд байна. | 100 |
| 2.1.8.4 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлж буй хүсэлтүүдийг цахим системээр дамжуулан хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Шийдвэрлэгдсэн хүсэлтийн тоо | Газрын кадастрын мэдээллийн санд нийт бүртгэсэн өргөдөл | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлж буй хүсэлтүүдийг цахим системээр дамжуулан хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгуулсан байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар газрын кадастрын цахим системд нийт 995 цахим хүсэлт ирсний 373 нь 2024 оны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд гэр бүлийн хэрэгцээнд үнэ төлбөргүй газар эзэмших хүсэлт бөгөөд үлдсэн 622 нь эрх шилжүүлэх, барьцаанд бүртгүүлэх, хугацаа сунгуулах, нэгтгэх, хуваах өргөдлийн төрлүүд байна. үүнээс 501 өргөдөл шийдвэрлэсэн, 8 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өргөдөл шийдвэрлэх шатандаа байгаа бөгөөд нийт өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлт 98 хувьтай байна. | |
| 2.1.8.5 | Нийт сумдын 2003 оноос хойш гарсан эрх бүхий этгээдийн шийдвэр тус бүрт хяналт хийж ГКМС-д бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган нөхөн бүрдүүлэх арга хэмжээг эцэслэн дуусгах | Үйл ажиллагаа | Захирамжийн тоо, нөхөн бүртгэж оруулсан нэгж талбарын тоо | Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй нэгж талбарын тоо | Эрх бүхий этгээдийн шийдвэр тус бүрт хяналт хийж ГКМС-д бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргасан байна. ГКМС-д нөхөн бүртгэх арга хэмжээ бүрэн дууссан байна. | ГЗБГЗЗЕГ-тай хамтран шалгалт хийж 2003 оноос хойш гарсан эрх бүхий этгээдийн шийдвэр, ГКМС-д бүртгэгдээгүй иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган ажилласан. Нийт 242 нэгж талбарыг нөхөн бүрдүүлэх шаардлагатай байна. Үүнд:<br>- Сүмбэр суманд 85,<br>- Шивээговь суманд 151,<br>- Баянтал суманд 6 нэгж талбар байгаагаас 72 нэгж талбарыг нөхөн бүрдүүлсэн. | 90 |
| 2.1.8.6 | Киоски төхөөрөмжийг хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийтэд нэг цэгээс түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэх | Орон нутгийн төсөв | Аймаг, сумдад шинээр нэвтрүүлсэн төхөөрөмжийн тоо | Улсын хэмжээнд 2022 оноос эхлэн нийт 21 төхөөрөмжийг нэвтрүүлсэн. | Киоски төхөөрөмжийг хүртээмж нэмэгдэж газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийт нэг цэгээс түргэн шуурхай авах боломж бүрдсэн байна. | 2023 онд аймгийн орон нутгийн хөгжил сангийн 23,0 сая төгрөгийн төсвөөр Сүмбэр суманд Киоск төхөөрөмжийг худалдан авч нэг цэгийн үйлчилгээгээр иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна.<br>Киоски төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Баянтал, Шивээговь сумдын Засаг дарга нарт 2025 оны төсөвт киоск төхөөрөмжийн төсвийг тусгуулах тухай байгууллагын 2024 оны 01/92 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан. | 100 |
| 2.1.8.7 | Киоски төхөөрөмжөөс иргэд олон нийтэд үзүүлж буй газартай холбоотой үйлчилгээнээс төлбөр тооцох боломжийг бүрдүүлж | Үйл ажиллага | Холбогдох байгууллагатай хийсэн гэрээ | 2023 онд төлбөр тооцох хөгжүүлэлтийг гүйцэтгсэн. | Холбогдох байгууллагатай гэрээ байгуулж Киоски төхөөрөмжөөс иргэд олон нийтэд үзүүлж буй газартай холбоотой үйлчилгээ төлбөртэй болсон байна. | 2023 оны 12 дугаар сард “ККТТ” ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулан ажилласан.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар киоски төхөөрөмж болон газрын цахим сайт болох www.egazar.gov.mn сайтаар иргэн, хуулийн этгээдэд төлбөртэй үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдох байгууллагатай гэрээ байгуулж ажиллах | | | | | | |
| 2.1.8.8 | Газрын кадастрын мэдээллийн сангийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах, өгөгдөл, мэдээлэл, цахим хавсралтыг үнэн зөв бүрдүүлж ажиллах | Үйл ажиллагаа | Системийн хэвийн үйл ажиллагаа | Газрын кадастрын мэдээллийн систем | ГКМС-ийг холбогдох журам, зааврын дагуу өгөгдөл мэдээллийг үнэн зөв бүртгэж өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна. | ГКМС-ийн мэдээллийг үнэн зөв бүртгэж өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хanган ажиллаж байна.<br>2024 оны 11 дүгээр сарын 11 өдөр батлагдсан Сумдын газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналт тавих ажлын удирдамжийн дагуу 2024 оны 11 дүгээр сайран 27-ны өдөр Шивээговь суманд очиж ажилласан. Энэхүү хяналт тавих ажлын хүрээнд Шивээговь суманд ГКМС-д үүссэн өргөдөлийг түүвэрлэн 20 нэгж талбарын хувийн хэргийг шалгаж үзхэд 1 нэгж талбарын бүрдэл хэсэгт дутагдал гарсаныг засварлуулан ажилласан байна. | 100 |
| 2.1.8.9 | ГКМС-д бүртгэгдсэн орон нутгийн тусгай хэрэгцээний газрын давхаргад хяналт шалгалт хийж буруу, зөрүүтэй бүртгэгдсэн мэдээллийг эрх бүхий этгээдийн шийдвэрт үндэслэн засварлах, сайжруулах, шинээр ОНТХ-нд авсан газрыг бүртгэж баталгаажуулах | Үйл ажиллагаа | Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газрын тоо | - | **Жилийн эцэст:**<br>Аймаг, сумдын хэмжээнд ОНТХ-нд авсан эрх бүхий этгээдийн шийдвэрийн судалгааг гаргаж ГКМС-д бүртгэгдсэн мэдээлэлд нэг бүрчлэн хяналт хийж, илэрсэн алдаа дутагдлыг засварласан байна. Шинээр авсан газрыг кадастрын нэгдсэн системд бүртгэж, баталгаажуулсан байна. | - 2023 онд газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн 17 орон нутгийн тусгай хамгаалалттай газрын мэдээллийг батлагдсан солбицолтой шалган шалгаж, засварлаж ажилласан.<br>- 2024 онд Баянтал суманд үйлдвэр технологийн паркийн зориулалтаар Орон нутгийн тусгай хэрэгцээнд 3380 га газрыг Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын мэдээллийн системд бүртгэж оруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.8.10 | Газрын нэгдмэл сангийн цахим системийн өгөгдөл, мэдээлэлд хяналт хийж, алдаатай, зөрүүтэй оруулсан мэдээллийг засварлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн цахим систем | Газрын нэгдмэл сангийн цахим систем | Газрын нэгдмэл сангийн цахим системийн мэдээлэл засварлагдсан байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар газрын кадастрын мэдээллийн системд зөрүүтэй оруулсан 7 нэгж талбарын алдааг байгууллагын 2024 оны 01/217 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэн засварлуулан ажилласан. | 100 |
| 2.1.8.11 | Газрын кадастрын мэдээллийн сангийн зөрчилтэй нэгж талбарын давхаргад хяналт хийж зөрчил арилсан мэдээллийг шинэчлэх, одоо байгаа болон шинээр илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажсан нэгж талбарын тоо | Газрын кадастрын мэдээллийн систем | Зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилган Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажуулсан байна. | Сүмбэр сумын 2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд дур мэдэн илүү эзэмшиж буй болон олон жил эзэмших эрхээ баталгаажуулаагүй амьдарсан газрын зөрчлийг арилгуулж шинээр эзэмшиж авахаар 10 нэгж талбар батлагдсан. Үүний 8 иргэдийн өргөдөл хүсэлтийг шийдвэрлэн ажилласан байна. | 100 |
| **2.1.9** | **Салбарын хэмжээнд сүлжээ, техник, програм хангамж, системийн хэвийн, аюулгүй, найдвартай үйл ажиллагааг хангах** | **Үйл ажиллагаа, урсгал төсөв, хөрөнгө оруулалт** | **Сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдварта** | **Байгууллагын дотоод сүлжээ домэйн удирдлагын системд холбогдсон. 21 аймаг тоон мэдээлэл дамжуулах байнгын холболтод холбогдсон. Мэдээллийн аюулгүй байдлын газрын Төрийн хамгаалалгдсан нэгдсэн сүлжээнд холбогдсон.** | **Сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажилласан байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **й ажиллагаа** | **Байгууллага, нийслэл, 21 аймаг, 345 цэг /сум, суурин, GNSS БАС/ интернэтийн сүлжээнд холбогдсон.** | | | |
| 2.1.9.1 | Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Байгууллагын сүлжээний төхөөрөмж болон Газрын даамлуудын VPN тусгаарласан сүлжээний төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангасан байдал | Аймаг, сумд интернэтийн сүлжээнд холбогдсон. | **Эхний хагас жилд:** Нийт сумдын Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболтын төхөөрөмж (Гэр интернэт)-ийг шинэчлэх ажлыг зохион байгуулаж, хэвийн ажиллагаанд оруулсан байна.<br>**Жилийн эцэст:** Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг хангасан байна. | Сумдын газрын даамлуудын гэр интернэтүүдийг шинэчилж, хурд болон хүчин чадал 4Mbps хурдаар 50 GB хэрэглээний хязгаартай байсныг 6Mbps хурдаар 60 GB болгон нэмэгдүүлсэний дагуу 2024 оны 2 дугаар сарын 1-ны өдөр холболтыг хийж ажилласан. Байгууллагын сүлжээний төхөөрөмж болон Газрын даамлуудын VPN сүлжээний үйл ажиллагаа 2024 оны 12 дугаар сарын байдлаар хэвийн байна. Байгууллагын дотоод сүлжээ домэйн удирдлагын системд холбогдсон. | 100 |
| 2.1.9.2 | Байгууллагад хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмж, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Техник, хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа | Асуудал гарсан тухай бүрд техник засвар үйлчилгээг цаг алдалгүй хийж хэвийн ажиллагааг хангасан. Байгууллагад хэрэглэгдэж буй бусад техник, тоног төхөөрөмж, хэрэглээний програм хангамжийн хэвийн, ажиллагааг ханган ажилласан. | - Байгууллагад хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа хангагдсан байна.<br>- Байгууллагад хэрэглэгдэж буй хэрэглээний програм хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангасан байна. | Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж буй компьютер, түүний дагалдах тоног төхөөрөмжүүдийн үйл ажиллагаа хэвийн шатсан, эвдэрсэн, дутсан, гэмтсэн тоног төхөөрөмж байхгүй программ хангамж, техник хангамжийн жижиг алдаанууд тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.10** | **Байгууллагын болон салбарын үйл ажиллагаанд шаардлагатай веб хуудас, программ хангамжийн хөгжүүлэлтийг хийх хэрэглээнд нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа, урсгал төсөв** | **3 цахим системийн нэмэлт хөгжүүлэлт** | **8 веб хуудас хэрэглээнд гаргасан.** | **3 цахим системийн нэмэлт хөгжүүлэлт хийж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.** | | |
| 2.1.10.1 | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем /Геопортал/-ийн дэд санг стандартын дагуу бүрдүүлэх | Үйл ажиллагаа | Дэд сан бүрээр бүрдүүлсэн өгөгдлийн тоо | 2023 онд Геопорталд дэд сан бүрээр өгөгдөл бүрдүүлсэн. | Хамаарах нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрдүүлсэн байрлалд суурилсан мэдээллийг орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем (Геопортал)-д 18 дэд сангийн стандартын дагуу баяжуулж, бүрдүүлсэн байна. | 2023 оны 11 дүгээр сард Геопортал цахим системд хандах эрхээ авч Сүмбэр суманд геодезийн хатуу цэг тэмдэгтийг нөхөн сэргээх, өтгөрүүлэлт хийх ажлын хүрээнд мэргэжлийн эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй “Климакс реферэнс” ХХК нь Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулан орон нутгийн хөгжлийн сангийн 8 сая төгрөгөөр GPS-2, Полигнометр-2 цэгийг шинээр нэмж суулгасан бөгөөд цэг тэмдэгтийн мэдээллийг Геопортал цахим системд оруулан ажилласан.<br>Мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн 2024 оны 2/3001 тоот албан бичгийн дагуу Улсын Их хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан газар зүйн нэршлийг 1:100000 масштабтай зурагтай тулган шалгаж байгууллагын 2024 оны 01/437 тоот албан бичгээр хариуг хүргүүлэн ажилласан. | 100 |
| **2.1.12** | **Салбарын архивын баримтаар хэрэглэгчдэд үйлчлэх** | **Үйл ажиллагаа** | **Цаасан болон цахим баримтын үйлчилгээ** | **1685 хадгаламжийн нэгжийн баримтаар үйлчилгээ үзүүлсэн.** | **Цаасан болон цахим баримтаар үйлчилгээ үзүүлсэн байна.** | | |
| 2.1.12.1 | Архивын баримтаар байгууллага, иргэдэд цахим | Үйл ажиллагаа | Ирүүлсэн хүсэлтийн дагуу үзүүлсэн | 2023 онд архивын баримтаар 85 хадгаламжийн нэгжийн баримтаар | Ирүүлсэн хүсэлтийн дагуу цаасан болон цахим баримтаар | 2024 оны байдлаар байгууллагын албан хаагчид архивын 94 баримт албан хэрэгцээнд ашигласан байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээ үзүүлэх, лавлагаа мэдээлэл олгох | | үйлчилгээний тоо, төрөл | байгууллага, аж ахуйн нэгж, иргэн болон байгууллагын дотоодын үйл ажиллагаанд үйлчилгээ үзүүлсэн. | үйлчилгээ үзүүлсэн байна. | | |
| **2.1.13** | **Төрийн архивын стандарт орчныг сайжруулах** | Үйл ажиллагаа | **Төрийн архивын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа** | - | **Төрийн архивын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.** | | |
| 2.1.13.1 | Архивын хадгаламжийн санг зориулалтын шүүгээ, тавиур, техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах талаар санал тавьж шийдвэрлүүлэх | Үйл ажиллагаа | Саналын тоо | Жил бүр архивын стандарт орчныг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулдаг. | **Эхний хагас жилд:** Архивын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай стандарт орчныг бүрдүүлэх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглох зардлын тооцоо гарган удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. **Жилийн эцэст:** Шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авсан байна. | Архивын хадгаламжийн санг зориулалтын шүүгээ, тавиур, техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгаа, төсвийн судалгааг гарган Narangerel.s@gazar.gov.mn хаягаар 2024 оны 09 сарын 05-ны өдөр хүргүүлсэн. 2024 онд EPSON DS-57OW II- хурдан скайнер авсан. | 100 |
| **2.1.14** | **Геодезийн хэмжилтийн багаж баталгаажуулалтын лабораторийн** | **Үйл ажиллагаа** | **Баталгаажуулсан багажны тоо** | **2022 онд улсын хэмжээнд 2325 багаж баталгаажуулсан.** | **2023 онд улсын хэмжээнд 1540 багажийг баталгаажуулсан байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **үйл ажиллагааг сайжруулах** | | | | | | |
| 2.1.14.1 | Аймгийн ГХБХБГ-т хэрэглэж буй геодезийн хэмжлийн багажийг баталгаажуулах | Үйл ажиллагаа | 5 багаж | 2023 онд аймгийн ГХБХБГ-т хэрэглэж байгаа нийт 5 багаж баталгаажуулалт хийлгэсэн. | 2023 онд баталгаажуулалт хийлгэсэн хугацаанд, бүх багажуудыг бүрэн хамруулсан байна. | 2024 оны 04-р сарын 21-ний өдөр геодезийн хэмжилтийн багажийг баталгаажуулан ажилласан. Үүнд:<br>• SET 530R- Электрон тахеометр /145375 хувийн дугаар/<br>• Trimble R4- 2 долгионы GNSS-ийн хүлээн авагч /5413460977 хувийн дугаар/<br>Trimble R4- 2 долгионы GNSS-ийн хүлээн авагч /5408455426 хувийн дугаар/-тай багажуудыг баталгаажуулсан байна. | 100 |
| 2.1.15 | **Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах** | **Үйл ажиллагаа** | **Иргэн, хуулийн этгээдийн тоо** | | **Эрсдэл үүсэх магадлалыг бууруулсан байна** | | |
| 2.1.15.1 | Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Төлөвлөгөөт бус шалгалт хийсэн объектын тоо | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.<br>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. | 2024 онд 2 хуулийн этгээд, 18 иргэний хүсэлт, өргөдлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, Зөрчлийн тухай хуулийн дагуу 18.5 сая төгрөгний торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилгав. | 100 |
| 2.1.15.2 | Эрх бүхий байгууллага, | Үйл ажиллагаа | Төлөвлөгөөт бус | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд | Салбарын улсын ерөнхий байцаагчийн төлөвлөгөөт бус шалгалтын батлагдсан 4 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | | шалгалт хийсэн объектын тоо | | хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Эрх бүхий байгууллага, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. | удирдамжийн дагуу 248 обьект болон цахим мэдээллийн санд хяналт шалгалтыг хийж 75 обьектийн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулж ажилласан. | |
| 2.1.15.3 | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авах | Үйл ажиллагаа | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тоо | - | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээг авсан байна. | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг аймгийн Прокурорын байгууллагын цахим хаягт илгээн нэгдсэн бүртгэлд 2024 онд 19 зөрчлийн хэргийг бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авч цахим санд бүртгүүлэн ажиллаж байна. | 100 |

**ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| **Д/д** | **Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **Суурь түвшин** | **Зорилтот түвшин** | **Хугацаа /I-IV улирал/** | **Хариуцах нэгж** |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3.1<br>Улсын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийнэ.** | | | | | | | |

| 3.1.1 | Газар зүйн нэрийн тодруулалт | Улсын болон орон нутгийн төсөв | Нэрийн тодруулалт хийх аймаг, сумын тоо | 2023 онд 11 аймгийн 35 сум, нийслэлийн 1 дүүрэг газар зүйн нэрийн тодруулалтын ажил хийсэн. | Нэрийн тодруулалт хийх ажлын төсөв батлагдсан аймаг, сумын газар зүйн нэрийн тодруулалт хийгдэж, мэдээллийн сан байгуулна. | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1.1 | Газар зүйн нэрийн тодруулалт хийх ажлыг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Сумын тоо | 2019-2022 онд 8 аймгийн 51 суманд Газар зүйн нэрийн тодруулалтын ажил хийсэн. | **Эхний хагас жилд:** Орон нутгийн төсөвт тусгагдсан аймаг, сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын даалгаврыг ГЗБГЗЗЕГ-тай хамтран боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулсан байна.<br>**Жилийн эцэст:** Газар зүйн нэрийн тодруулалтын ажлын үр дүнг хүлээн авсан байна. | Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан үүсгэх ажлын даалгаврыг боловсруулан ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэн батлуулсан.<br><br>Шивээговь сумын газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 07 дугаар тогтоолоор батлуулан ажилласан.<br><br>Баянтал сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан үүсгэх ажлыг Климакс реферэнс ХХК нь хийж гүйцэтгэн сумын газар зүйн нэрийн салбар зөвлөлд хүлээлгэн өгсөн бөгөөд 12 дугаар сарын 05-ны өдөр болох сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хэлэлцүүлэхээр сумын Засаг даргын 2024 оны 359 тоот албан бичгээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн бариад байна.<br><br>Сүмбэр сумын газар зүйн нэрийн тодруулалтын үргэлжлэл ажлыг “Тэгш хэм” групп хийхээр тендерт шалгарсан бөгөөд сумын Засаг даргатай 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажилласан. Дээрх ажлын тайланг хэлэлцэх шатандаа ажиллаж байна. | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1.2 | Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах | Урсгал төсөв | 2 хурал | 2023 оны Газар зүйн нэрийн зөвлөлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан. 4 удаа газар зүйн нэрийн зөвлөлийн хурлыг зохион байгуулсан. | **Эхний хагас жилд:** Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулах, 1 удаагийн хурлыг зохион байгуулж, хурлын тэмдэглэлийг баталгаажуулан ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. **Жилийн эцэст:** Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж, хурлын тэмдэглэлийг баталгаажуулан ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн гишүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаж байна.<br>- 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Шивээговь сумын газар зүйн нэрийн салбар зөвлөл хуралдаж Шивээговь сумын газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг хүлээн авч сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 07 дугаар тогтоолоор дэмжсэн байна.<br>- Баянтал сум газар зүйн нэрийн зөвлөл 2024 оны 09 дүгээр сард хуралдан Климакс реферэнс ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хэлэлцсэн. | 100 |
| **3.1.3** | **Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Бэлчээрийн фото мониторингийн 5166 цэг** | **2022 онд Бэлчээрийн фото мониторингийн 5166 цэгт бэлчээрийн фотомониторингийн ажлыг зохион байгуулсан.** | **Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн 320 сумын хэмжээнд бэлчээрийн газрын 5166 мониторингийн цэгт хийсэн байна.** | | |
| 3.1.3.1 | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах | Үйл ажиллагаа | Аймгийн хэмжээнд байгуулсан мониторингийн цэгийн тоо | 2023 онд 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн бэлчээрийн газарт фото мониторингийн ажлыг зохион байгуулагдсан. | **Жилийн эцэст:** 2024 оны бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан нэгтгэж, холбогдох зөвлөмжийг гаргаж, | Аймгийн хэмжээнд бэлчээрийн фото мониторингийн хээрийн судалгааны 48 цэгтэй бөгөөд 3 сумын хэмжээнд фото мониторингийн ажлыг 8 дугаар сарын 7-10 хооронд хийж гүйцэтгэсэн. Тайлан мэдээг ГЗБГЗЗЕГ-т байгууллагын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 01/348 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын мониторингийн цахим системд бүрэн оруулж, тайланг 10 сарын 01-ны дотор хүргүүлсэн байна. | | |
| 3.1.3.2 | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх журам, арга зүйг сайжруулах талаар санал боловсруулах | Үйл ажиллагаа | Санал-1 | Газрын даргын 2015 оны А/105 дугаар тушаалаар "Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх журам" батлагдсан. | Зайнаас тандан судлалын аргуудын талаар мэдээлэл цуглуулж, фото мониторингийн арга зүйн дутагдалтай болон давхардалд дүн шинжилгээ хийж, алдаа дутагдал, сайжруулах талаар Газрын даамлуудаас судалгаа авч, нэгтгэн ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Сансрын болон хиймэл дагуулын зургийг ашиглан https://mongolia.sibelius-datacube.org/ сайтын тусламжтайгаар бэлчээрийн биомасс болон элэгдэл эвдрэлд орсон газрыг тодорхойлохоор боловсруулалтыг хийж байна. Боловсруулалтын үр дүнг хээрийн судалгааны ажлын үр дүнтэй харьцуулан 12 сарын 10-ны дотор хүргүүлнэ. | 100 |
| 3.1.3.3 | Бэлчээрийн фото мониторингийн багаж хэрэгслийг шинэчлэх шаардлагатай сумдын судалгааг гаргах, мөн багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Багаж, хэрэгслийн тоо | - | **Эхний хагас жилд:** Бэлчээрийн фото мониторингийн багаж хэрэгслийг шинэчлэх судалгааг гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлж, багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулсан байна. | Аймгийн хэмжээнд бэлчээрийн фото мониторингийн багаж хэрэгсэл муудсан, эвдэрсэн шинэчлэх шаардлагатай байгаа сумдын судалгааг нэгтгэн ГЗБГЗЗЕГ-т байгууллагын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/349 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан. Мөн метр, цагаан самбар, гадас зэргээр шаардлагатай багаж хэрэгслийг байгууллагаас ханган ажилласан. | 100 |
| **3.1.4** | **Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах** | **Үйл ажиллагаа** | **Төлөвлөгөөт болон захиалгат хянан баталгаа хийгдсэн тоо** | **Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийсэн ажлын тайлан мэдээ** | **Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх ажлыг зохион байгуулахад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж, хянан баталгааны үр дүнг мониторингийн цахим** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **системд оруулсан байна.** | | |
| 3.1.4.1 | Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийж, цахимаар болон хэвлэмэл байдлаар ирүүлсэн тайлан, дүгнэлтийг хянаж, баталгаажуулах | Үйл ажиллагаа | Захиалгат хянан баталгаа хийж, баталгаажсан тайлан, дүгнэлтийн тоо | 2023 онд нийт 298 тайлан, дүгнэлт баталгаажуулсан. | **Эхний хагас жилд:** Цахим системээр хянан баталгааны тайлан, дүгнэлтийг баталгаажуулахад гарч буй алдаа, зөрчлийг засварлаж, тайлангийн үр дүнг сайжруулсан байна. Цахимаар илгээсэн хянан баталгааны тайлан, дүгнэлтийг хянаж баталгаажуулсан байна. **Жилийн эцэст:** Цахимаар илгээсэн хянан баталгааны тайлан, дүгнэлтийг хянаж баталгаажуулсан байна. | Цахим системээр дамжуулан 2024 оны жилийн эцсийн байдлаар 167 нэгж талбарын хянан баталгааг цахимаар ирүүлснийг хянаж баталгаажуулан ГЗБГЗЗГ-т байгууллагын 2024 оны 01/173, 01/369 тоот албан бичгээр захиалгат хянан баталгааны нэгдсэн мэдээллийг хүргүүлэн ажилласан. | 100 |
| 3.1.4.2 | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлыг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Орон нутгийн төсвөөр хийгдсэн ажлын тоо | - | **Эхний хагас жилд:** Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлын даалгаврыг боловсруулж, | 2020 онд аймгийн орон нутгийн 9,2 сая төгрөгийн төсвөөр Жемр ХХК нь аймгийн хэмжээний хот тосгон, бусад суурин газар, бэлчээрийн газрын төлөв байдалд төлөвлөгөөт хянан баталгааг хийн хүлээлгэн өгсөн.<br><br>Дээрх төлөвлөгөөт хянан баталгааны хугацаа 2025 онд дуусаж байгаа | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | агентлагаас санал авч батлуулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлын эцсийн шатны тайланг хянаж, ажлын үр дүн, тоон мэдээллийг гүйцэтгэгч байгууллагаар газрын мониторингийн цахим системд оруулахад хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна. | бөгөөд орон нутгийн 2025 оны төсөвт газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлын төсөв болох **114 сая төгрөгийн** зардлыг тусгуулахаар болж 2025 оны төсвийн төсөлд туссан. Аймгийн ИТХ 2024 оны 12 сарын 05-ны өдөр хуралдаж төсөв батлагдана. | |
| 3.1.4.3 | Атар газраас тариалангийн ангилалд шилжүүлэх саналыг судлаж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санал, дүгнэлт боловсруулах. | Үйл ажиллагаа | Ирүүлсэн саналын тоо | ”Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг гаргаж, тус газрын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 1/1171 тоот албан бичгээр Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн. | **Эхний хагас жилд:** Атар газрын ангилал шилжүүлэхээр холбогдох байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийг судлан шийдвэрлэсэн байна.<br>**Жилийн эцэст:** Атар газрын ангилал шилжүүлэхээр холбогдох байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийг судлан шийдвэрлэсэн байна. | 2023 онд атар газраас тариалангийн ангилалд шилжүүлэхээр 7500 га газрын хээрийн судалгаа, хэмжилт зураглалыг ХАА-н газартай хамтран гарган ажилласан. тус судалгааны үр дүнг сумын ИТХ-аар хэлэлцүүлэхээр ХАА-н газраас өргөн барьсан байна. | 100 |
| **3.1.5** | **Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх** | **Үйл ажиллага а** | **Газар зохион байгуулал т, хот төлөвлөл тийн цахим** | **21 аймгийн 330 сумын 2022 оны сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө** | **Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүрэн оруулж,** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | системд оруулсан төслийн тоо | боловсруулсан байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. | хэрэгжилтэнд системээр хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулсан байна. | | |
| 3.1.5.1 | Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнах | Үйл ажиллагаа | Бүх сум | Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө хэрэгжилт болон газар олголтын байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгаж тайлагнасан байна.<br>Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг 12 дугаар сарын 20-ны дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Сумдын 2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө болон нэмэлт тодотголыг Засгийн газрын 2024 оны 136, 74, 131 дугаар тогтоолоор баталсан. Үүнд:<br>• Гэр бүлийн хэрэгцээ, төрийн байгууллагад эзэмшүүлэхээр 113 нэгж талбарын 886,15 га газар<br>• Аж ахуйн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулахаар 23 нэгж талбарын 4867,61 га газрыг тус тус батлуулан ажилласан.<br><br>Дээрх 136 нэгж талбарыг газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүрэн оруулсан. 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 70 нэгж талбарын 2298,40 га газрыг аймаг, сумдын Засаг даргын захирамж шийдвэрээр олгоод байна.<br>Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг 12 дугаар сарын 20-ны дотор хүргүүлэхээр ажиллаж байна. | 100 |
| 3.1.5.2 | Сумын газрын даамлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр | Үйл ажиллагаа | 4 сургалт | - | Улиралд нэг удаа цахим болон танхимаар сургалт зохион байгуулсан байна. | Газрын удирдлагын мэргэжилтнүүд болон сумдын газрын даамлуудын ажиллах ур чадварыг дээшлүүлэх, сайжруулах, мэргэжил арга зүйгээр хангах, цахим систем, программ хангамжийн хөгжүүлэлт, даамлуудын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах, сургалт зохион байгуулах | | | | Сургалт зохион байгуулсан тайлан мэдээг тухай бүр тайлагнасан байна. | хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, туршлага судлуулах, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 07, 2024 оны 05 дугаар сарын 03, 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдөр тус тус 3 удаа сургалт зохион байгуулан ажилласан. | |
| 3.1.5.3 | Монгол улсын иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтын саналыг 2024 оны 3 дугаар улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | 2025 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын санал | Жил бүр хийгддэг. | **Жилийн эцэст:**<br>Иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг сум тус бүрээр гаргаж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Монгол улсын иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр аймгийн Засаг даргын 2024 оны А/1176 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан.<br>Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хуралдахаар тов гарсан болно. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.5.4 | 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулах ажлыг зохион байгуулж, тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг гарган хүргүүлэх | Үйл ажиллагаа | 2024 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын санал | - | **Жилийн эцэст:** Аймгийн хэмжээнд сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг 2024 оны 3-р улиралд багтаан баталгаажуулах ажлыг зохион байгуулж, тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг батлах тухай тогтоолын төсөлд тусгах саналаа 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Сумдын 2025 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний төслийг 3 дугаар улиралд багтаан баталгаажуулж байгууллагын 2024 оны 01/404 тоот албан бичгээр дүгнэлт авахаар ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэн ажилласан.<br><br>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас 2024 оны 1/3131 тоот албан бичгээр дүгнэлтийг ирүүлсэн бөгөөд дүгнэлтийн дагуу 2025 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. | 100 |
| **3.1.6** | **Улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх** | **Үйл ажиллага а** | **Газрыг улсын тусгай хэрэгцээн д авсан Засгийн газрын тогтоол** | **Засгийн газрын тогтоолын дагуу улсын тусгай хэрэгцээнд авсан 3 газрын гэрээ гэрчилгээг олгох ажлын зохион байгуулсан.** | **Улсын тусгай хэрэгцээнд газрыг авах, гаргах асуудлын хэрэгцээ, шаардлагыг судлах, холбогдох судалгаа хийж, дүгнэлт гаргаж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлсэн байна.** | | |
| 3.1.6.1 | Байгалийн хий дамжуулах хоолой, түүнийг дагалдах барилга байгууламжууд баригдах газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын тусгай | Үйл ажиллагаа | Аймгийн ИТХ-ын тогтоол | Засгийн газрын хуралдааны 2021 оны 55 дугаар тэмдэглэл гарсан. | **Эхний хагас жилд:** Байгалийн хий дамжуулах хоолой, түүнийг дагалдах барилга байгууламжууд баригдах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг аймгийн | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн 2024 оны А/02 тоот албан бичиг болон Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолын дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр тогтоолоор Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх хий | **100** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгцээнд авах саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн тогтоолын эх хувийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | | | | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, тогтоолын эх хувийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | дамжуулах хоолой, барилга, байгууламж барих газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах саналыг батлуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт уламжлан хүргүүлэн ажилласан. | |
| **3.1.7** | **Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл, газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хянах** | **Үйл ажиллагаа** | **Газрын нэгдмэл сангийн 2021 оны улсын нэгдсэн тайлан** | **Газрын нэгдмэл сангийн 2020 оны улсын нэгдсэн тайлан Засгийн газарт танилцуулагдсан.** | **Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэлийн үйл ажиллагааг эрхэлж газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн бүртгэгдсэн байна.** | | |
| 3.1.7.1 | Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайланг сумдаас авч нэгтгэн, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайлан | Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | **Жилийн эцэст:** Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайланг хуульд заасан хугацаанд хүлээн авч нэгтгэн, дараа оны 01 сарын 15-ны өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | 2023 оны газрын нэгдмэл сангийн тайланг сумдын газрын даамлуудаас авч нэгтгэн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн 2024 оны 01/07 тоот албан бичгийн дагуу тайлан мэдээг холбогдох албан хаагчдын имэйл хаягаар болон газрын нэгдмэл сангийн мэдээллийн сангаар илгээн ажилласан. | 100 |
| 3.1.7.2 | Газрын нэгдмэл сангийн тайланг Газрын нэгдмэл сангийн мэдээллийн системээс гаргах ажлын хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн тайлан | - | **Жилийн эцэст:** Газрын нэгдмэл сангийн тайланг Газрын нэгдмэл сангийн мэдээллийн системээс гаргасан байна. | Газрын нэгдмэл сангийн мэдээллийн системээр дамжуулан 10 төрлийн тайланг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт илгээн ажилласан. Үүнд:<br>• Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалын ГНСТ-1<br>• Газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангилалын ГНСТ-2 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Шилжилт хөдөлгөөний ГНСТ-4<br>• Газрын эрх зүйн байдлын тайлан ГНСТ-5<br>• Газрын улсын бүртгэлийн ГНСТ-6<br>• Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газрын тайлан ГНСТ-7<br>• Улсын тусгай хэрэгцээний тайлан ГНСТ-3<br>• Газрын төлбөр ногдуулалт, төлөлтийн тайлан ГНСТ-8<br>• Газарт учруулсан хохирлын тайлан ГНСТ-9<br><br>Газар хамгаалах, нөхөн сэргээсэн арга хэмжээний тайлан ГНСТ-10 | |
| **3.1.9** | **Салбарын архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан хөмрөг үүсгэх, архивлах** | **Үйл ажиллагаа** | **30 ажил Баянзүрх дүүргийн нэгж талбарын хувийн хэрэг** | **2021 онд 65 ажлын бүрдлийг шалгаж акт үйлдэн хүлээн авсан. Налайх дүүргийн нэгж талбарын хувийн хэргийн баримтыг хүлээн авсан.** | **Төрийн архивт хүлээлгэн өгөхөөр ирүүлсэн 30 ажлыг шалгаж акт үйлдэн хүлээн авна. Баянзүрх дүүргийн 35543 нэгж талбарын хувийн хэргийн 678 хадгаламжийн нэгжийн баримтыг төрийн архивт хүлээн авсан байна.** | | |
| 3.1.9.1 | Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон архивт ирүүлсэн ажлыг хүлээн авах | Үйл ажиллагаа | Үүсгэсэн хадгаламжийн нэгжийн тоо | 2023 онд 64 ажлын бүрдлийг шалгаж акт үйлдэн хүлээн авсан. | **Эхний хагас жилд:** . Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон архивт ирүүлсэн ажлыг хүлээн авч, данс бүртгэл үүсгэсэн байна.<br>**Жилийн эцэст:** | 2024 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 03 сарын 15-ний өдөр байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын 01 хурлаар хэлэлцэн, Газрын даргаар батлуулан ажилласан.<br>Байгууллагын 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу нийт 85 хадгаламжийн нэгжид 2024 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон гэрээт ажлын хүрээнд хийж төрийн архивт ирүүлсэн ажлыг хүлээн авч, данс бүртгэл үүсгэсэн байна. Архивт хадгалагдаж байгаа баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалт, өөрчлөлт, хөдөлгөөний мэдээлэл болон нэгж талбарын хувийн хэргийн судалгааг загварын дагуу гаргаж, 12 дугаар сарын 10-ны дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | онд нягтлан шалгалт хийж, акт үйлдэн хүлээн авч архивласан. | |
| 3.1.9.2 | Аймгийн ГХБХБГ-ын архивт нэгж талбарын хувийн хэргийг сумдаас татан төвлөрүүлэх | Үйл ажиллагаа | Татан төвлөрүүлсэн нэгж талбарын хувийн хэргийн тоо | ГЗБГЗЗЕГ-аас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, зааварчилгааны дагуу нэгж талбарын хувийн хэргийн баримтыг цэгцэлсэн. | **Эхний хагас жилд:**<br>3 сумын 150 хувийн хэргийн бүрдлийг шалган акт үйлдэн хүлээн авч, мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>3 сумын 300 хувийн хэргийн бүрдлийг шалган акт үйлдэн хүлээн авч, мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Сумдын газрын даамлуудын ажиллах ур чадварыг дээшлүүлэх, сайжруулах, мэргэжил арга зүйгээр хангах сургалт зохион байгуулж тус сургалтаар нэгж талбарын хувийн хэргийг цахим болон цаасан байдлаар журмын дагуу бүрдүүлэх талаар чиглэл тухайн сумдууд байршуулж байна.<br>Аймгийн ГХБХБГ-ын архивт нэгж талбарын хувийн хэрэг татах өрөө тасалгааны хувьд хүндрэлтэй байгааг Орон нутгийн удирдлага болон ГЗБГЗЗЕГ-ын удирдлагуудад тухайн асуудлыг шийдвэрлэх талаар саналууд тавьж ажиллаж байна. | 70 |
| **3.1.11** | **Хот байгуулалтын үйл ажиллагааны хэрэгжилт** | **Үйл ажиллагаа** | **Хэрэгжүүлсэн арга хэмжээ** | **-** | **Хот байгуулалтын чиглэлээр хийгдэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **зохион байгуулсан байна.** | | |
| 3.1.11.1 | Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хууль тогтоомжийн дагуу боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Аймгийн Иргэдийн Төлөөлөгч дийн Хурлаар батлуулсан баримт бичгийн тоо | - | **Эхний хагас жилд:** “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д шинээр батлагдсан хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний мэдээллийг оруулсан байна. | Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр “Сонголт дизайн” ХХК шалгарч, 2023-2024 онд хэмэгчилсэн төлөвлөгөөг боловсруулан, Барилгын хөгжлийн төвийн 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 0648/2024 дугаар магадлалын дүгнэлтээр батлагдсан бөгөөд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 тогтоолоор батлуулж, хүлээлгэн өгсөн. Төлөвлөгөөний мэдээллийг цахим системд оруулсан байна. | 90 |
| 3.1.11.2 | Монгол Улсын Засгийн газрын 2023 ны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлийн хэрэгжилтийг ханган ажиллах | Үйл ажиллагаа | Зардлын хэмжээ | Улсын хэмжээнд 162 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсан. | **Эхний хагас жилд:** Монгол Улсын Засгийн газрын 2023 ны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлтэй холбоотойгоор төлөвлөгөө боловсруулах даалгаврын төслийг холбогдох норм, дүрмийн дагуу боловсруулан баталгаажуулж шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгах ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Форум арт ХХК 2014 онд, Баянтал сумын хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг ХБХДТ ХХК 2013 онд, Шивээговь сумын хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Нарт дизайн ХХК 2013 онуудад хийж гүйцэтгэн аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.<br><br>Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр “Сонголт дизайн” ХХК шалгарч, 2023-2024 онд хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулан, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 тогтоолоор батлуулж, хүлээлгэн өгсөн. Төлөвлөгөөний мэдээллийг цахим системд оруулан ажилласан.<br><br>Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар тогтоолоор 2024 оны орон нутгийн төсөв сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний 93,2 сая төгрөгийн төсвийг батлуулан ажилласан.<br><br>Байгууллагын 2024 оны 01/11 тоот албан бичгээр ГЗБГЗЕГ-т сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний ажлын даалгаврыг боловсруулан батлуулахаар хүргүүлсний дагуу ГЗБГЗЕГ-с 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр ажлын даалгаврыг баталж ирүүлсэн.<br><br>Дээрх төлөвлөгөөг Ланд овнер ХХК нь хийж гүйцэтгэж байна. | |
| **3.1.12** | **Барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын сүлжээний мэдээллийг “Урбан менежер систем”-д бүртгэх** | **Үйл ажиллагаа** | **-** | **21 аймгийн 330 сумын мэдээлэл бүртгэгдсэн.** | **Улсын хэмжээнд барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын сүлжээний мэдээллийг бүртгэсэн байна.** | | |
| 3.1.12.1 | Шинээр барих барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, | Үйл ажиллагаа | Системд бүртгэсэн мэдээллийн тоо | Бүх сумдын барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн дэд бүтцийн мэдээлэл бүртгэгдсэн. | **Эхний хагас жилд:** Шинээр нэмэгдсэн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн дэд | Жилийн эцсийн байдлаар шинээр байнгын ашиглалтад орсон цахилгаан хангамжийн 9, барилга угсралтын 2 ажлын мэдээллийг цахим системд бүртгэн баяжуулалт хийн ажиллаж байна. Үүнд:<br>➢ Сүмбэр сумын ОНХС-н хөрөнгө оруулалтаар Өлзийт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | инженерийн дэд бүтцийн мэдээллийг “Урбан менежер систем”-д бүртгэх | | | | бүтцийн мэдээллийг бүртгэсэн байна.<br>**Жилийн эцэст:**<br>Шинээр нэмэгдсэн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн дэд бүтцийг мэдээллийг бүртгэсэн байна. | суурьшлын бүсийн гадна цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх сайжруулах ажлын гүйцэтгэл;<br>➢ Сүмбэр сумын ОНХС-н хөрөнгө оруулалтаар Наран шинэ суурьшлын бүсэд татагдсан цахилгааны гүйцэтгэл<br>➢ Аймгийн ОНХС-н 350,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүмбэр сумын 2-р багт Халуун усны барилга угсралтын ажлын гүйцэтгэл<br>➢ Аймгийн ОНХС-н 198,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бурхант суурьшлын бүсэд татагдсан цахилгааны гүйцэтгэл<br>➢ Улсын төсвийн 349,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвд татагдсан бохирын шугамын гүйцэтгэл<br>➢ Улсын төсвийн 2,1 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Шивээговь сумын 150 ортой цэцэрлэгийн гүйцэтгэл<br>➢ Аймгийн ОНСХ-ын 169,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Тагтын эгнээнд ухаалаг худаг, цэвэр усны шугам татсан ажлын гүйцэтгэл<br>➢ Сүмбэр сумын ОНХС-н 182,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар МСҮТ-ийн урд уулзвараас төв зам хүртлэх авто замын гэрэлтүүлэгийн гүйцэтгэл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.12.2 | Хот байгуулалтын кадастрын цахим систем /Urban.gov.mn/-д өгөгдөл мэдээллийг бүрэн оруулж холбогдох журам, зааврын дагуу өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах | Үйл ажиллагаа | Хот байгуулалтын кадастрын цахим систем /Urban.gov.mn/-д шинээр бүртгэгдсэн өгөгдөл, мэдээлэл | Хот байгуулалтын кадастрын цахим систем /Urban.gov.mn/ хэрэглээнд нэвтэрсэн. | Хот байгуулалтын кадастрын цахим систем /Urban.gov.mn/-д шаардлагатай өгөгдөл, мэдээлэл бүртгэгдэж холбогдох журам зааврын дагуу барилга, байгууламжийн бүртгэл, мэдээлэл хөтлөгдөж системийн өдөр тутмын үйл ажиллагаа тогтмол хийгдсэн байна. | -Байнгын ашиглалтад орсон болон ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн бүртгэл мэдээллийг хөтлөх, цахим системийн мэдээллийг сурталчилах зэрэг өдөр тутамын үйл ажилагаанд тогтмол баяжилт хийн ажиллаж байна.Үүнд:<br>-Иргэн, хуулийн этгээдээс барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотой хүсэлтийг хүлээн авч 4 аж ахуйн нэгж байгууллагын барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ шинээр олгох үйлчилгээг шийдвэрлэсэн.<br>- Байнгын ашиглалтад орсон цахилгаан хангамжийн 9, барилга угсралтын 2 ажлын мэдээллийг цахим системд бүртгэлжүүлсэн. | 100 |
| **3.1.14** | **Худалдан авах ажлыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **1 Төлөвлөгөө, 2 тайлан, ажил үйлчилгээний тоо** | **Ерөнхий төлөвлөгөөнд туссан 12 ажил, үйлчилгээний худалдан авалтыг хийж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, гэрээт ажлыг хүлээн авсан.** | **Ерөнхий төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөн туссан ажлууд бүрэн хэрэгжиж, тайланг хагас, бүтэн жилээр гаргаж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.** | | |
| 3.1.14.1 | Байгууллагын 2024 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулах, тайлагнах | Үйл ажиллагаа | 1 Төлөвлөгөө, 2 тайлан | 2023 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөө батлуулсан. | Худалдан авах ерөнхий төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулсан байна. Тайланг хагас, бүтэн жилээр гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Байгууллагын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Газрын даргаар батлуулан ажиллаж байна.Үүнд:<br>✓ Бичиг хэрэг 472,8 мян. Төг<br>✓ Тээвэр шатахуун 2,744,2 мян төг<br>✓ Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс 434,4 мян төг<br>✓ Барилгын лабораторийн багаж тоног төхрөөмж 35,0 сая төг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Компьютер, принтер, тавилга эд хогшил 30,0 сая төгрөг<br>✓ Барилга техник хяналтын шатахуун 20,0 сая төг<br><br>Бусдаар гүйцэтгүүлсэн ажмл үйлчилгээ 20,0 сая төгрөгөөр тус тус батлуулан ажиллаж байна. | |

**ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| **Д/д** | **Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж** | **Төсөв** | **Шалгуур үзүүлэлт** | **Суурь түвшин** | **Зорилтот түвшин** | **Хугацаа /I-IV улирал/** | **Хариуцах нэгж** |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4.1.1** | **Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Тухай бүр** | **-** | | | |
| 4.1.1.1 | Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухай бүр | - | Хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байна. | 2024 оны хагас жилийн байдлаар 5 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдэл олгох асуудлыг шийдвэрлүүлэн холбогдох, хууль журамд заасны дагуу нэмэгдлийг олгон ажиллаж байна.<br>Мөн төрийн албан хаасан хугацааны нэмэгдлүүдийг тухай бүр олгон ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1.2 | Сул болон түр эзгүй байгаа орон тоог Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сул болон эзгүй орон тоо | - | - Сул болон түр эзгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам", "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна<br>- Тухайн албан тушаалд нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулах, дүгнэлтийг үндэслэн шийдвэрийн төсөл боловсруулан албажуулах ажлыг зохион байгуулсан байна. | - Сул орон тооны захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд 2024 оны байдлаар Газрын даргын 2024 оны 01/28, 01/108, 01/185, 01/230, 01/278, 01/328, 01/329, 01/407 дугаар албан бичгүүдээр нийт 8 удаа захиалга өгч зарлуулсан байна. Мөн аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар 01/184 тоот албан бичгээр сул орон тооны захиалга өгсөн байна.<br>**Үүний үр дүнд** 1 албан хаагч ерөнхий болон тусгай шалгалтанд тэнцэж сул орон тоог нөхөн ажиллаж байна. | 100 |
| 4.1.1.3 | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөсөн арга хэмжээний тоо | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр" /2021-2025/-ыг баталсан. | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж, биелэлтийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах 2024 оны төлөвлөгөөг 02 дугаар сарын 19-ний өдөр 20 арга хэмжээгээр төлөвлөн Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.<br>2024 оны байдлаар Аймгийн Засаг даргын тамгын газар 100% хэрэгжилттэй тайлагнаж танилцуулсан.<br>Үүний үр дүнд албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангагдаж сэтгэл ханамж өндөр байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1.4 | Салбарын хэмжээнд “Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Салбарын хэмжээнд Жэндерийн талаарх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. | Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөг боловсруулан 2024.03.30-ны өдөр байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ГЗБГЗЗЕГ-т гүйцэтгэлийн төлөвлөгөөний хамт хүргүүлэн ажилласан. | 100 |
| 4.1.1.5 | “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо” цахим системд мэдээллийг оруулах, тухай бүр шинэчлэх | Үйл ажиллагаа | Албан хаагчийн тоо | - | “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо” цахим системд мэдээллийг оруулах, тухай бүр шинэчилсэн байна. | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын ерөнхий даргын 2023 оны Б/10 тоот тушаалын дагуу байгууллагын даргын 2024 оны А/01 тоот тушаалаар байгууллагын бүтэц орон тоог батласан.<br>2024 оны байдлаар “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо” цахим системд манай байгууллагын 17 нь албан хаагч бүртгэлтэй бөгөөд тухай бүр мэдээллийг шинэчлэж ажиллаж байна. Үүний үр дүнд албан хаагчийн цалин хөлс мэдээлэл цаг тухай бүр орж, албан хаагчдын сэтгэл ханамж өндөр байна. | 100 |
| 4.1.1.6 | Хүний нөөцийн тоо бүртгэл, бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээ, судалгааг ГЗБГЗЗЕГ-т ирүүлэх | Үйл ажиллагаа | Мэдээ, судалгааны тоо | - | Хүний нөөцийн чиглэлээрх салбарын албан хаагчдын бүх төрлийн нэгдсэн судалгаа, мэдээллийг цуглуулж, нэгтгэн цаг хугацаанд нь ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Хүний нөөцийн судалгааг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр шэйр файлаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлсэн. | 100 |
| **4.1.2** | **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **12 удаа** | **-** | **Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг заасан хугацаанд оруулсан байна.** | | |
| 4.1.2.1 | Шилэн дансны тухай хуулийн | Үйл ажиллагаа | Мэдээллийн тоо | - | Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын бараа, ажил үйлчилгээ | www.shilendans.gov.mn сайтанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн мэдээллийг хуулийн хугацаанд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангах | | | | худалдан авах ерөнхий төлөвлөгөө, тайлан, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг сар бүр оруулж баталгаажуулсан байна. | нь нийт 140 ш мэдээллийг бүрэн байршуулан ажилласан.Үүнд:<br>• Сар бүр цэсэнд 40 ш<br>• Хагас жил бүр цэсэнд 4 ш<br>• Жил бүр цэсэнд 5 ш<br>• Тухай бүр цэсэнд 91 ш мэдээллийг тус тус байршуулж мэдээлсэн.<br>• Аудитын дүгнэлтийн биелэлтийг аудитын “Баталгаат тооцоолол” ХХК-д биелэлтийн 05 дугаар сарын 15-ны өдөр 02/156 тоот албан бичгээр хүргүүлэн ажилласан.Үүнд:<br>• Актын төлбөрийн бүрэн барагдуулсан<br>• Шилэн дансы мэдээллийг хуулийн хугацаанд нь хоцролтгүй мэдээлсэн<br>• Байгууллагын дотоод хяналтын ажлыг дотоод хяналт хариуцсан ажилтан төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажилласан.<br>Үр дүнд: Санхүүгийн үйл ажиллаганы мэдээлэл тухай бүрд нээлттэй ил тод тогтмол байршсан. | |
| **4.1.3** | **Авлигын тухай болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **1 төлөвлөгөө,<br>3 тайлан,** | **-** | **Төлөвлөө болон тайланг холбогдох байгууллагад хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.3.1 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнах | Үйл ажиллагаа | Тайлангийн тоо | 2022 онд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн. | Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Газрын даргаар батлуулсан байна Хэрэгжилтийг хангаж, тайланг ГЗБГЗЗЕГ-т хагас, бүтэн жилээр хүргүүлсэн байна. | Авлигын эсрэг 2024 оны төлөвлөгөөг нийт 16 арга хэмжээтэйгээр төлөвлөж 03 дугаар сарын 15-ны өдөр газрын даргаар батлуулсан.<br>Мөн байгууллагад "Шударга ёс хөгжил дэвшилд-110" мэдээллийн самбарыг ажиллуулахаас гадна байгууллагын фасебүүк пейж, веб сайтаар видео бичлэг, танилцуулгыг тухай бүр дамжуулан иргэд олон нийтэд түгээн ажиллаж байна.<br>Авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 99.1%-ийн биелэлттэй тайлагнагдсан бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний хамт хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | 100 |
| 4.1.3.2 | Албан тушаалтнуудын 2022 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үйл ажиллагааг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Мэдүүлэг гаргагчийн тоо | 2021 оны тайланг хугацаанд нь хүргүүлсэн. | Албан тушаалтнуудын 2022 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө авах ажлыг зохион байгуулсан байна. | 2024 онд байгууллагын 7 албан хаагч хуулийн хугацаанд Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ гарган баталгаажуулж,<br>2024 оны 01 дүгээр сарын 03-ний 01/02 албан тоотоор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст Хувийн ашиг сониорхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын жагсаалт, тайланг хүргүүлэн ажилласан. | 100 |
| 4.1.3.3 | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хүлээн авч бүртгэх | Үйл ажиллагаа | Мэдүүлгийн тоо | - | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг албан хаагчдаас хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | Албан хаагчдаас 2024 оны байдлаар Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх тохиолдол, шаардлага гараагүй болно. | 100 |
| 4.1.3.4 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан | Үйл ажиллагаа | Мэдүүлгийн тоо | - | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай | 2024 оны байдлаар шинээр нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд байхгүй байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдүүлэх ажлыг зохион байгуулах | | | | тэмцэх газарт хүргүүлсэн байна. | | |
| **4.1.4** | **Тогтоол шийдвэрийн, биелэлтэд хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Тогтоол шийдвэрийн бүртгэл хөтөлсөн байдал** | **78 тогтоол шийдвэрийн биелэлтийг журамд заасан хугацаанд тайлагнасан.** | **Бүртгэлд авсан тогтоол шийдвэрийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журамд заасан хугацаанд холбогдох газарт тайлагнасан байна.** | | |
| 4.1.4.1 | Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Барилга, хот байгуулалтын яам, ГЗБГЗЗЕГ болон бусад байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | - | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хүлээн авч бүртгэлжүүлэн, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр холбогдох газарт тайлагнасан байна. | 2024 оны байдлаар 15 бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийг бүртгэлжүүлэн, хяналтад авсан байна. Үүнд:<br>• МУ Барилга, хот байгуулалтын сайдын тушаал, даалгавар - 2<br>• Засгийн газрын тогтоол -1<br>• ГЗБГЗЗЕГ даргын тушаал – 4<br>• ГЗБГЗЗЕГ даалгавар - 1<br>• Засгийн газрын захирамж-6<br>• МУ-н ерөнхий прокурорын тушаал 2 тус тус бүртгэж хэрэгжилтийг хагас жилийн байдлаар гарган аймагт болон ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэн ажилласан. | 100 |
| **4.1.5** | **Байгууллагын хэмжээнд эрх зүйн баримт бичиг боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **380 тушаал, 280 гэрээ, 1 журам, 1 эмхэтгэл** | **-** | **Тушаал болон гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, дугаар олгож бүртгэсэн байна. Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт орж батлагдсан байна. Эмхэтгэл бэлэн болсон байна.** | | |
| 4.1.5.1 | Газрын даргын тушаалын үндэслэлийг хянаж, бүртгэх, хэрэгжилтийг | Үйл ажиллагаа | Тушаалын төслийн тоо | 2023 онд 83 тушаал гарч албажсан байна. | Газрын даргын тушаалын төслийг боловсруулж, бүртгэл хөтөлж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион | 2024 оны байдлаар Газрын даргын А тушаал 15, Б тушаал 36 гарсан бөгөөд тушаалын дэвтэрт бүртгэн хэрэгжилтийг 100% хангаж ажилласан. Газрын даргын тушаалын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах ажлыг зохион байгуулах | | | | байгуулж, хэрэгжилтийн тайланг гаргасан байна. | төслийг боловсруулж хянуулан бүртгэж ажилладаг.<br>Мөн А тушаалуудыг тухай бүр байгууллагын цахим хуудсанд байршуулан ажилласан. | |
| 4.1.5.2 | Байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, албажуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Шинэчлэн боловсруулсан дүрэм, журмын тоо | - | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцэж Газрын даргын А/25 дугаар тушаалаар баталсан.<br>2024 оны байдлаар байгууллагын дотоод журамд нэмэлт өөрчлөлт ороогүй болно. | 100 |
| **4.1.6** | **Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, дүгнэх ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан загвар, аргачлал** | **Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор журам шинэчлэн батлагдсан.** | **Журманд заасан хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг тайлагнасан байна.** | | |
| 4.1.6.1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Үнэлгээний мөрөөр авсан арга хэмжээний тоо | 2023 онд албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг жилээр, гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр гарган үнэлгээ, дүгнэлт өгч ажилласан. | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах ажлыг зохион байгуулж, биелэлтийг үнэлж, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.<br>2024 оны хагас жилийн байдлаар албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэн. Үр дүнгийн урамшуулалд 16 албан хаагчдад нийт 20,223.4 мян.төгрөг зарцуулсан байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4.1.7** | **Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдалтын хувь** | **-** | **Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрхтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.** | | |
| 4.1.7.1 | Сумын газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Үйл ажиллагаа | Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан сумдын тоо | - | Сумын газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг хэлэлцэж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | Газрын даргын 2024.11.11-ний өдөр сумдын газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжийг боловсруулан батлуулж<br>❖ Сүмбэр суманд- 2024.11.28-29<br>❖ Шивээговь суманд- 2024.11.27<br>Баянтал суманд- 2024.11.22-ний өдрүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулж заавар зөвлөгөө өгч ажилласан байна. | 100 |
| **4.1.8** | **Хурал, зөвлөгөөн зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | | **2021 онд 5 хурал, 3 зөвлөгөөн зохион байгуулагдсан.** | **Хурал, зөвлөгөөн, форумыг хугацаанд нь зохион байгуулж, биелэлтийг тайлагнасан байна.** | | |
| 4.1.8.1 | Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд зарлагдсан “Бүтээлч ажил”-ыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | Бүтээлч ажлын тоо, Хэрэгжилтийн байдал | - | Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн арга хэмжээний төлөвлөгөө болон зарлагдсан бүтээлч ажлуудыг орон нутагтаа зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ний өдөр Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд зарлагдсан “Бүтээлч ажил”-ыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 27 үйл ажиллагаа төлөвлөж тухайн төлөвлөгөөний тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэхээр ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4.1.9** | **Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь** | **Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр батлагдсан.** | **Хөтөлбөрийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.** | | |
| 4.1.9.1 | Батлагдсан “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сургалтын тоо | - | “Салбарын хэмжээнд байгууллагаас хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө“-г боловсруулан Газрын даргаар батлуулж, хэрэгжүүлж ажилласан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | “Сургалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах 2024 оны төлөвлөгөөг 04 дүгээр сарын 16-ны өдөр байгууллагын даргаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. 2024 оны байдлаар сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт 100%-ийн хэрэгжилттэй байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хамт хүргүүлсэн. | 100 |
| 4.1.9.2 | Салбарын хууль тогооомжийн хүрээнд ГХБХБГ-ын албан хаагчдыг болон сумдын газрын даамлуудыг мэргэжил арга зүгээр хангаж, сургалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар болон салбарын хууль тогооомжийн хүрээнд байгууллагын албан хаагчид, сумын газрын даамлуудад сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүгээр хангаж ажилласан байна. | Газрын удирдлагын мэргэжилтэнүүд болон сумдын газрын даамлуудын ажиллах ур чадварыг дээшлүүлэх, сайжруулах, мэргэжил арга зүйгээр хангах, цахим систем, программ хангамжийн хөгжүүлэлт, даамлуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, туршлага судлуулах, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2024.05.03-ний өдөр сургалт зохион байгуулан ажилласан.<br>Тус сургалтаар :<br> Газар эзэмших ашиглах өмчлөх эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны журам болон MLE цахим системийн хэрэглээний талаар<br> Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн цахим систем, хэрэглээ болон 2024 оны сумдын газар зохион байгуулалтын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тухайн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх байдал, 2025 онд анхаарах асуудал<br> Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын 2021 оны А/187 дугаар журам "Газар эзэмших ашиглах гэрчилгээ олгох журам"-н танилцуулга, орон нутагт тулгамдсан асуудал<br> Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын 2010 оны 497 дугаар журам "Сумын Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал,-н танилцуулга, орон нутагт тулгамдсан асуудал<br> Албан хэрэг хөтлөлтийн стандарт болон ERP төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн мэдээлэл ашиглах талаар тус тус мэдээлэл солилцож ажилласан.<br>Мөн шинээр томилогдсон албан хаагчдыг чадавхижуулах зорилгоор 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдөр сумдын газрын даамлууд болон газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн нарт сургалт хийн ажилласан. | |
| **4.1.10** | **Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод, шуурхай байх нөхцөл боломжийг бүрдүүлэх** | **Үйл ажиллагаа** | - | - | **Байгууллагын үйл ажиллагааны мэдээ олон нийтэд шуурхай хүрдэг болсон байна.** | | |
| 4.1.10.1 | Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр сурталчилсан. | Салбарын үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээг орон нутгийн хэмжээнд сурталчлан таниулж, нийтэд хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | - Газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ний өдөр Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд зарлагдсан "Бүтээлч ажил"-36 арга хэмжээ<br>- Бүсчилсэн хөгжлийг дэмжих- Хариуцлагатай газрын харилцаа"-ны жилийн хүрээнд аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө-36 арга хэмжээ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - “Хариуцлагатай газрын харилцаа” 2 сарын аян-26 арга хэмжээ<br>- Сумдын нээлттэй хаалганы өдөрлөг-3 сум<br>- Багуудын өдөрлөг -10 баг-358 иргэн<br>- Аж ахуйн нэгж байгууллагад мэдээллийн цаг-64 байгууллага<br>- Сумдын багийн Засаг дарга нар болон нийгмийн ажилтнгуудад зориулсан сургалт-14 албан хаагч<br><br>Байгууллагын вэб сайт болон пэйж хуудсанд нийт 39 мэдээ мэдээлэл байршуулж 1048 хандалт авсан байна. | |
| **4.1.11** | **Албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагааны зардал** | **Баримт бичиг** | **2022 онд 3600 албан бичиг, 500 өргөдөл, гомдол хүлээн авсан.** | **Газарт ирсэн, явсан, өргөдөл гомдолыг “Байгууллагын удирдлагын цогц цахим систем”-д бүртгэлжүүлж, тайлан мэдээг гаргасан байна.** | | |
| 4.1.11.1 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэж, тайлагнах | Үйл ажиллагаа | Ирүүлсэн албан бичгийн тоо, Явуулсан албан бичгийн тоо, Өргөдлийн тоо, Тайлангийн тоо | 2023 онд 667 албан бичиг, 86 өргөдөл, гомдол хүлээн авч, 441 албан бичигт дугаар олгон холбогдох иргэн, хуулийн этгээдэд хүргүүлсэн. | - Байгууллагад ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг бүртгэж, холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байна.<br>- Байгууллагаас явуулж буй албан бичгийг бүртгэж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.<br>- Хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийн мэдээ тайланг тухай бүр гаргаж, тайлагнасан байна.<br>- Өргөдөл, гомдлын мэдээг холбогдох | - 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 636 албан бичиг ирснийг тухай бүр нь Газрын даргын цохолтын дагуу албан хэрэг хөтлөлтийн able программд бүртгэж холбогдох албан тушаалтанд шилжүүлэн ажилласан.<br><br>-2024 оны 12 сарын 03-ны өдрийн байдлаар 437 бичгийг явуулсан бөгөөд 100% цахим программд бүртгэж холбогдох байгууллагуудад цахимаар болон бичгээр хүргүүлэн ажилласан.<br><br>-Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийг байгууллага дотооддоо хянах зорилгоор сар бүр мэдээг гарган газрын даргад танилцуулан ажилладаг.<br><br>-Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг улирал бүр өссөн дүнгээр гаргаж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагад улирал бүр тайлагнасан байна. | аймгийн Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэн ажилласан. Үүнд: 1 дүгээр улирлын тайланг 01/78 дугаар албан бичгээр, 2 дугаар улирлын тайланг 01/234 дугаар албан бичгээр, 3 дугаар улирлын тайланг 01/323 дугаар бичгээр хүргүүлээд байна. Мөн байгууллагын сайт, мэдээллийн самбарт 1, дүгээр улирлын өргөдөл, гомдлын мэдээг тухай бүр иргэдэд ойлгомжтой тоон үзүүлэлтээр гарган байршуулж ажилласан. | |
| **4.1.12** | **Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **Хадгаламжийн нэгж** | **Байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2022 онд 358 хадгаламжийн нэгж үүсгэсэн.** | **Байгууллагын архивт баримт хүлээн авах, бүртгэх, нягтлан шалгалт хийх, тоо бүртгэл хөтлөх, тооллого явуулах, хадгалах, хамгаалах, ашиглуулах, данс бүртгэл хөтлөх, устгах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулсан байна.** | | |
| 4.1.12.1 | Байгууллагын архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан хөмрөг үүсгэх, архивлах | Үйл ажиллагаа | Хадгаламжийн нэгжийн тоо | 2023 онд Байгууллагын хөтөлж дууссан баримтыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн архивласан. | 2024 оны байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, нөхөн бүрдүүлэх хуваарь гарган батлуулсан байна. 2023 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт” болон нөхөн бүрдүүлэх хуваарийн дагуу хөтөлж дууссан баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивласан байна. | 2024 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 03 сарын 15-ний өдөр байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын 01 хурлаар хэлэлцэн, Газрын даргаар батлуулан ажилласан. Байгууллагын 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу нийт 95 хадгаламжийн нэгжид нягтлан шалгалт хийж архивласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.12.2 | Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын дотоод зохион байгуулалтын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг зохион байгуулж, байгууллагын архивын чиг үүргийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | - | **Эхний хагас жилд:** Архивын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гаргаж, Улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангасан байна. **Жилийн эцэст:** Улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлж, дүгнүүлсэн байна. | Архивын Улсын үзлэгт бэлтгэн 10 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулж байгууллагын даргаар 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |
| **4.2.1** | **Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа тогтвортой хэрэгжүүлэх** | **-** | **Санхүүгийн хяналт шалгалтын дүн** | **Төсвийн тухай болон НББ-н тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг ил тод тайлагнаж ажилладаг.** | **Санхүүгийн зөрчилгүй ажилласан байна.** | | |
| 4.2.1.1 | Төсвийн зардлыг бууруулж, хэмнэлт гаргаж ажиллах, бараа материалын болон үйлчилгээний орлогод хяналт тавьж орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-н тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна. Орлогын төлөвлөгөөг биелүүлж санхүү төсвийн зөрчилгүй ажилласан байна. | Байгууллагын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт, хэтрэлт, түүний тайлбарын хамт www.shilendans.gov.mn сайтны сар бүрийн цэсэнд дараа сарын 8-ны дотор буюу хуулийн хугацаанд нь нийт 1-11 дүгээр сарын мэдээллийг бүрэн байршуулан ажилласан.<br>- 2024 оны жилийн нийт батлагдсан төсөв 829,587.5 мян.төгрөг. 11-р сарын 30-ны байдлаар батлагдсан төсөв 772,459.7 мян, төгрөг, гүйцэтгэл нь 642,947,7 мян.төгрөг, хэмнэлт 121,394.2 мян.төгрөгийн мэдээлийг байршуулсан. Нийт хэмнэгдсэн зардал Үүнд:<br>❖ Цалин хөлс 83,598.5 мян.төг<br>❖ Ажил олгогчоос НДШ 11,453.6 мян.төг<br>❖ Байр ашиглалттай холбоотой зардал 3,187.0 мян.төг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ❖ Хангамж, бараа материал 184.5 мян.төг<br>❖ Урсгал засвар 24.4 мян.төг<br>❖ Томилолт 3,187.4 мян. төгрөг<br>❖ БҮАҮТөлбөр 3.2 мян мян.төг<br>❖ Бусад зардал 193.6 мян.төг<br>❖ Байр ашиглалтын үйлчилгээний 67.4 мян.төг<br>❖ Тэтгэмж, урамшуулал 746.6 мян.төг<br>❖ Барилга, техник хяналт 11,390.9 мян.төг<br>❖ Орлогын төлөвлөгөө нийт 120.0 сая төгрөг, гүйцэтгэл нь 102.0 төгрөгөөр төвлөрүүлэн ажилласан. Үүнд: Барилга, техник хяналтын орлого 100.0 сая төгрөг, үндсэн газрын үйл ажиллагааны орлого 2,0 сая төгрөг тус тус төвлөрүүлэн ажилласан. Төсвийн хэмнэлт нь сул орон тооны албан хаагчийн цалин, бусад үйл ажиллагааны зардлыг сар хэмнэж ажилласан. Хүлээгдэж буй гүйцэтгэл нь жилийн эцэст зардлын зүйл ангиар төсвийн хэтрэлтгүй зарцуулагдан гарах болно. Хуримтлагдсан авлага 4,6 сая төгрөгийг бүрэн барагдуулан ажилласан.<br>**Үр дүн:** Төсөв хэмнэсний үр дүнд тайлант хугацаанд өглөг, авлага үүсгээгүй ажилласан.Үр дүн: Байгууллагын төсвийг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж тайлант хугацаанд шинээр өглөг, авлага үүсгээгүй ажилласан. Тайлант хугацаанд санхүүгийн ямар нэгэн зөрчил гаргаагүй ажилласан. | |
| 4.2.1.2 | Байгууллагын санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж, аудитын дүгнэлт гаргуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Санхүүгийн тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. | 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг дээд шатны байгууллага болон Аймгийн төрийн аудитын газарт хуулийн хугацаанд хүргүүлж, зөрчилгүй санал дүгнэлт авч ажилласан. Үр дүнд: Өөрчлөлтгүй санал дүгнэлт авч санүүгийн зарчилгүй ажилласан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.1.3 | Өр авлагыг цаг тухайд нь барагдуулж, өмнөх оныхоос бууруулж ажиллах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Үүссэн өр, авлагыг цаг тухайд нь барагдуулж тайлант жилд өр, авлагыг бууруулан ажилласан байна. | 2023 оны жилийн эцсийн авлага 4,6 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан. Тайлант хугацаанд шинээр өглөг, авлага үүсгээгүй ажилласан.<br>Үр дүнд: Санхүүгийн сахилга батыг сахиж ажилласан | 100 |
| 4.2.1.4 | Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хагас, бүтэн жилээр тооллого зохион байгуулах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Үндсэн хөрөнгийн болон бараа материалын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж ажилласан байна. | Байгууллагын өмчид бүртгэлтэй өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулах зорилгоор хагас бүтэн жилээр төлөвлөн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/07 тоот тушаалаар хагас жилийн тооллогыг хуулийн хугацаа буюу 6 дугаар сард зохион байгуулж ажилласан. Тооллогоор дутагдсан болон илүүдэл хөрөнгө байхгүй, хөрөнгийн хадгалалт хамгаалалт сайн байсан. 2023 оны өмч эзэмшүүлэх гэрээг 98,9 хувьтай дүгнүүлэн ажилласан. Жилийн эцсийн тооллогын үйл ажиллагааг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>Үр дүнд: Дутагдсан болон эвдрэл гэмтэлтэй хөрөнгө байхгүй хадгалалт хамгаалалт сайжирсан. | 100 |
| 4.2.1.5 | Санхүү болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, татвар, НДШ-ийн тайлан, Шилэн дансанд оруулах мэдээллийг хууль журамд заасан хугацаанд оруулж мэдээ тайланг холбогдох газруудад хүргүүлсэн байна. | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Хуульд заасан хугацаанд мэдээ тайланг тайлагнаж ажилласан байна. Мэдээ тайлангийн хугацааг хоцроохгүй байх. | - 2024 оны тайлант хугацаанд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг баталгаажуулан дээд шатны байгууллагад хугацаанд нь цахимаар хүргүүлж ажилласан.<br>- Аймгийн нийгмийн даатгал хэлтэст сар бүрийн нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд нь цахимаар болон цаасаар баталгаажуулан гарган хүргүүлж ажилласан.<br>- Аймгийн татварын хэлтэст цалин хөлсний болон ХХОАТ-ын тайланг улирал бүр хуулийн хугацаaанд гарган цахимаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон цаасаар баталгаажуулан хүргүүлж ажилласан.Тайлант хугацааны шилэн дансы нийт 151 ширхэг мэдээллийг хугацаанд байршуулан ажилласан. Үүнд:<br>- Сар бүр цэсэнд 44 ш<br>- Хагас жил бүр цэсэнд 4 ш<br>- Жил бүр цэсэнд 5 ш<br>- Тухай бүр цэсэнд 98 ш мэдээллийг тус тус 100 хувь байршуулан ажилласан.<br>Үр дүнд: Санхүүгийн зөрчилгүй, шилэн дансны мэдээлэл тухай бүрд нь оруулж хугацаа хоцролтгүй, төсвийн гүйцэтгэл сар бүр хугацаандаа тайлагнагдсан. | |
| Нийт хувь | | | | | | 98,8 | |